

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +24
Шөнө +15

ОРОН НУТАГ

Б.ЦЭВЭЛМАА: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО БОЛ БИДНИЙ НЭГДЭЛ

VII нүүрт

ЗАВСАРЛАГА

ӨНДӨР ГЭГЭЭНИЙ НУТГИЙНХАН ӨРГӨН ДЭЛГЭР НААДАВ

VIII нүүрт

Дугаарын **60** мөр
Зам, 00-ын асуудлаа шийдчихвэл ч Н.БОЛД

ҮЗЭЛ БОДОЛ



Ерөнхийлөгч өө, ЭНЭ ЭРЧЭЭЭРЭЭ АЖИЛЛААРАЙ

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга тангаргаа өргөж, ажлаа эхэлснээс хойш нэг сарын хугацаа ч өнгөрөөгүй байна. Энэ хугацаанд цөөнгүй шийдвэрийг гаргаж, олон ч хүнтэй уулзаж, нөхцөл байдал ямар байгааг мэдэж авлаа. Ерөөсөө ажлаа шуурхай эхэлж байна. Гараа сайн байгааг олон хүн хэлж, сайшааж, магтаж байгаа юм. Наадмаас хойш Ерөнхийлөгч гал түймэртэй бүс нутагт өөрийн биеэр очиж ажиллаж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авахыг холбогдох хүмүүст нь даалгасан. Онцгой байдлынхан, гал түймэртэй тэмцэгчдийн техник хэрэгслийг сайжруулах, хүн хүрч болохгүй газарт гарч буй галыг унтраах зорилго бүхий онгоц авах ажлыг шийдвэрлэхийг ч сануулсан, даалгасан. Түүний энэ үйлдлийг Оросын Ерөнхийлөгч Путиныг дуурайлаа хэмээн харлуулах хэсэг бүлэг ч бас байна. Ц.Элбэгдорж ч ингэж шуудаж, ард түмнээс сайн нэр олох гэж явсан ч гэх шиг. Түүрүү түүрүүчийн Ерөнхийлөгч нараас нэг их гал түймэр гарсан газар өөрийн биеэр очоод, онцгой байдлынханд урам дэм өгөөд, бусад сайд, дарга нарыг хөдөлгөөд байсан хүн бий бил үү. Сайн санахгүй л байна. Ерөнхийлөгч нь өөрийн биеэр гал түймэр гарч байгаа бүсэд очоод, ажиллаад, шийдвэрлэх асуудал юу байна гээд явахаар сайдууд хүртэл ялхайгаад суугаад байдаггүй юм байна. Энэ чинь үлгэж, худлаа ярьж биш үлгэрлэж ажиллаж байгаагийн тод жишээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Р.ПҮРЭВДАГВА ганшиг наадамг ГУРАВ ДАРААЛАН түрүүлээ

О.УЯНГА

Гурван жилийн өмнөөс уламжлал болгон зохион байгуулагдаж байгаа “Даншиг-хүрээ цам” наадмын бөхийн барилдаан өчигдөр өндөрлөлөө. Өнөө жилийн Даншиг наадамд аварга Р.Пүрэвдагва, начин Б.Пүрэвсайхан, улсын заан Н.Түвшинбаяр, Б.Соронзонболд тэргүүтэй 256 бөх барилдсан юм. Тэгвэл энэ жилийн Даншиг наадамд Даншигийн аварга Р.Пүрэвдагва улсын заан Б.Соронзонболдоор найм даван гурав дахь удаагаа түрүүлээ. Даншиг наадам зохион байгуулж эхэлснээс хойш Р.Пүрэвдагва арслан ийн гурав дараалан түрүүлж, Даншигийн дайн аварга цол хүртлээ. Тэгвэл улсын заан Б.Соронзонболд үзүүлж, Даншигийн заан цол хүрсэн юм. Харин улсын заан Б.Пүрэвсайхан, улсын гарьд Б.Гончигдамба нар шөвгийн дөрөвт шалгарлаа.

МЭДЭЭЛЭЛ

П.СЭРГЭЛЭН: НЭГЖЭЭС ХУРААН АВАХ УРГАЦЫН ХЭМЖЭЭ ЭРС БУУРАХ МАГАДЛАЛТАЙ БАЙНА

Э.ТУУЛ

Улсын онцгой комисс энэ сарын 03-нд өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар хуралдлаа. Энэхүү хуралдааны эхэнд Хүнсхөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн зуншлага, ургацын байдал, отор нүүдэл, өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв. ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн “Манай орны нийт нутгаар зуншлага оройтож байгааг холбогдуулан бүх аймгийн Засаг дарга, ХХААГ-ын дарга нарыг оролцуулсан цахим хурал зохион байгуулж

мал оторлолт, хадлан тэжээл бэлтгэл, мал сүргийг эрүүл мэндийн урьчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах, өвчний голомт бүхий газруудад вакцинжуулалт хийх, ургацын урьдчилсан балансыг наймдугаар сарын 18-ны дотор гаргах, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг сайтар хангах талаар үүрэг даалгавар өглөө. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн Ховд, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Булган, Төв, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Хэнтий,

Сүхбаатар, Дорнодын зарим нутгаар буюу нийт 150 орчим сумдын нутгаар гантай, Увс, Завхан, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Хэнтийн зарим нутгаар буюу нийт 50 гаруй суманд гандуу байна гэсэн гангийн үнэлгээ хийгээд байна. Үүнтэй холбогдуулан манай яам бүх аймгийн ХХААГазраас зуншлагын байдал, ургацын төлөв байдал, мал өвөлжилтийн бэлтгэл ажлын урьдчилсан дүн мэдээг авч нэгтгэн дүгнэлт хийж төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Үргэлжлэл нь II нүүрт

ДЭЛХИЙ



НҮБ Хойд Солонгосын эсрэг хориггоо чангатгаж, Ш.Абэ Засгийн газраа шинэчилсэн долоо хоног

Б.ДАВААХҮҮ

Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа өрсөсөн онцлох үйл явдлын талаар тоймлон хүргэе.

Хойд Солонгосын ашигт малтмалын экспортод хориг тавилаа

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл энэ сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Хойд Солонгосын нүүрс, төмөр, төмрийн хүдэр, хар тугалга зэрэг ашигт малтмалын бүх экспортод хориг тавих тухай АНУ-ын саналыг хэлэлцэж, 100 хувь дэмжлээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

Нийтлэл · Яри

БҮХ СЭДЭВ

Шилдэг · Архив

зугаагаа 2017

expo

50%

НИЙГЭМ МАРГААШН ЭХЭЛНЭ 2 цагийн өмнө

ШАР МЭДЭЭ

НИЙГЭМ МАРГААШНААС БҮСЭЭ ЧАНГАЛАХ САР ЭХЭЛНЭ 2 цагийн өмнө

АСЕМ-ын “Ази-Европын Хүнсний аюулгүй байдал”-ын

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAХ PLAY STORE

TATAХ APP STORE

САНАЛ БОЛГОХ ШИНЭ МЭДЭЭ

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2450.00	2469.00	ФУНТ	3180.00	3265.00
ЕВРО	2881.00	2948.00	РУБЛЬ	39.80	41.80
ИЕН	22.19	22.63	ЮАНЬ	363.50	367.50

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2444.00	2464.00	ФУНТ	3157.00	3286.00
ЕВРО	2865.00	2971.00	РУБЛЬ	38.58	43.54
ИЕН	21.80	22.82	ЮАНЬ	363.00	366.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

П.СЭРГЭЛЭН: НЭГЖЭЭС ХУРААН АВАХ УРГАЦЫН ХЭМЖЭЭ ЭРС БУУРАХ МАГАДЛАЛТАЙ БАЙНА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Аймгуудаас авсан мэдээгээр нийт нутгийн 23 хувь нь зуншлага хэвийн, 43 хувь нь ганцдуу, 34 хувь нь ганцтай байна. Энэ жил улсын хэмжээнд нийт 1629 багийн 177.5 мянган малчин өрх бэлтгэлд нийлүүлэх мал махаа тооцон 66.0 сая толгой мал өвөлжих урьдчилсан тооцоо гарч орон нутагт мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Өөр аймгийн нутагт өвөлжих магадлалтай 2921 өрхийн 1.1 сая, бусад сумдын нутагт өвөлжих магадлалтай 9225 өрхийн 3.6 сая, сум дундын отрын бүс нутагт 490 өрхийн 369 мянга, аймаг дундын отрын бүс нутагт 1151 өрхийн 843.0 мянга, хилийн зурвасгазарт 3104 өрхийн 1.2 сая, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 4502 өрхийн 2.1 сая, нийт 21393 өрхийн 9.2 сая мал отроор өвөлжүүлж, хаваржуулаа гэсэн тооцоог аймгууд хийсэн байна. 2017 оны хавар 517.4 мянган га-д тариалалт хийснээс үр тариа 391.6 мянган га-д, үүнээс улаанбуудай 367.2 мянган га-д, төмс 14.6 мянган га-д, хүнсний ногоо 7.2 мянган га-д, тосны ургамал 75.9 мянган га-д, тэжээлийн ургамал 25.7 мянган га-д, эмийн ургамал 1.9 мянган га-д, жимс, жимсгэнэ 287.1 га-д тус тус тариалсан. Тариалалтын чанарыг соёлолтоор хүлээн авах ажлыг зургадугаар сарын 15-20-ны хооронд зохион байгуулж, 13 аймгийн 84 сумын 1198 аж ахуйн нэгж, иргэдийн 366.9 мянган га улаанбуудайн талбайг хамруулснаар нийт тариалсан талбайн 75.5 хувь



нь соёлолтоор онц, сайн үнэлгээтэй байсан боловч буудайн өсөлт хөгжилтийн чийгэнд хамгийн эмзэг үе буюу бутлагтаас гол хатгалтын шатанд тариалангийн ихэнх бүс нутгийг хамарч хур тунадас багатай, зарим бүс нутгуудад огт хур тунадасгүй, 3-4 удаагийн 6-10 орчим хоног үргэлжилсэн нарны хэт их халалт явагдсан нь ургацын байдалд сөргөөр нөлөөлөө. Энэхүү байгалийн гамшигт үзэгдэл нь нэг аймгийн, нэг сумын нутагт харилцан адилгүй явагдаж, улмаар хур тунадас нь зурваслан аадар хэлбэрээр орж байсан бол нарны хэт халалт нь бүс нутгийн ялгаваргүйгээр бүхэлдээ өндөр буюу 32-41 хэмд хүрч халсан. Нарны хэт их халалт, хур тунадасны дутагдлын улмаас бүх бүс нутгуудад тариалагдсан таримлын өсөлт хөгжилт саарч удааширнаар үр тариа, улаанбуудайн бутлагт байхгүй,

намхан давжаа, жижиг товчин түрүү гарч улмаар нэгжээс хураан авах ургацын хэмжээ эрс буурах магадлалтай байна. Төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын ургац ч мөн ганц өртөж, хураан авах ургацын хэмжээ төлөвлөснөөс 20 орчим хувиар буурахаар байна. Энэхүү төлвөөр Сэлэнгэ, Булган аймгийн хойд талын бүс нутаг, Дархан-Уул, Орхон, Увс, Хөвсгөл, Архангай аймгийн зарим сумдын ургацын байдал харьцангуй дээр буюу нэгжээс 9.0-12.0 цн ургац авахаар байгаа бол Төв аймагт 30.5 мянган га, Сэлэнгэ аймагт 18.7 мянган га, Булган аймагт 8.5 мянган га, Дорнод аймагт 6.7 мянган га, Хэнтий аймагт 4.8 мянган га, Өвөрхангай аймагт 3.9 мянган га, нийтдээ 74.6 мянган га улаанбуудайн талбайгаас ургац авах боломжгүй буюу тэжээлд шилжүүлэн хураах магадлалтай байна. Түүнчлэн гангийн улмаас

бэлчээрийн ургамал хатаж гандсанаар царцаа, оготого болон бусад хортон шавьж тариалангийн талбайд нүүдлэн орж таримлын ургацд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд эрсдлийг бууруулах зорилгоор ургамал хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Цаашдаа энэ сард тариалангийн бүс нутгаар хур тунадас хэвийн, нарны хэт халалтын эрчим буурах магадлалтай байгаа тул ургац хураалтын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 2018 оны өвөл хаврын бэлчээрийн даацны судалгааг энэ сарын 20-нд гаргана. Иймд манай яам наймдугаар сарын 10-наас эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг орон нутагт томилж бэлчээрийн болон хадлангийн ургацыг тогтоох,

мэргэжлийн зөвлөгөө өгөх, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийг эрчимжүүлэхээр төлөвлөж байна. Ургац хураалт, мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар ХХААХУ-ийн сайдын албан даалгаварыг гаргаад байна. Мөн хөдөө аж ахуйн салбарын 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж байна. ХХААХУ-ийн Яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан шуурхай штаб ажиллаж байна” гэж мэдээлэв. Түүнчлэн Засгийн газрын 186 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 30.8 мянган тонн өвс, 11.7 мянган тонн тэжээл бэлтгэх үүрэг даалгавар өгөөд байгаа аж. Мөн энэ жилийн хадлан бэлтгэлд 7101 дугуйт трактор, 5806 бага

оврын тракторууд дагалдах хэрэгслийн хамт, 621 хаман боогч, 1000 морин хадуур, 5000 гар болон хөдөлгөөнт хадуур, тармуур ажиллахад бэлэн болжээ. Малчдын хувьд 1.2 сая тонн өвс, 36.0 мянган тонн сүрэл, 23.0 мянган тонн ногоон тэжээл, 48.9 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 71.0 мянган тонн гар тэжээл, 9.0 мянган тонн дарш, 141.9 мянган тонн давс, хужир бэлтгэх юм байна. 2017 оны төсвийн нэмэлт тодотгоолоор бэлчээрийн усан хангамжийг сайжруулах шинээр худаг гаргах ажилд хөрөнгө оруулалт батлан нийт 17 аймаг тус бүрт 2-оос 12 хүртэлх нийт 96 инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг зохион байгуулж, ажилд нь оруулжээ. Бэлчээрт нийт 45.3 мянган худаг уст цэг байгаагаас 40.1 мянга нь ашиглахад бэлэн байгаа бөгөөд мал аж ахуй эрхэлж байгаа өрхүүдийн 92.1 хувь нь усаар хангагдаад байгаа аж. Үлдсэн усаар хангагдаагүй өрхийг усжуулахын тулд 2017 онд 295 худаг уст цэгийг шинээр барьж байгуулах, 340 энгийн уурхайн болон гар худгуудыг засварлах боломжтой гэнэ. Мөн энэ онд бэлчээрт шинээр гаргах боломжтой худаг уст цэгүүдийг улсын төсвийн хөрөнгө болон гадаадын төсөл хөтөлбөр, орон нутаг өөрийн хөрөнгө, малчдын санаачилгаар гаргаж байгаа аж. Түүнчлэн энэ онд бодын 355, богийн 575 хашааг шинээр барьж, улсын хэмжээнд бодын 68313 хашаа, богийн 135332 хашаа байгаа нь хашааны хангамж 98 хувьтай байна. Харин бэлчээрийн ургамал хамгаалах арга хэмжээний хүрээнд царцаатай тэмцэх ажлыг гурван аймагт 89.8 мянган га талбайд, үлийн цагаан огототой микро-биологийн аргаар тэмцэх ажлыг хоёр аймгийн 100.0 мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж байгаа юм байна.

MINFO

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:

С.ГАНТГОГО

Орлогч эрхлэгч:

Ч.ЧУЛУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:

Б.ӨНӨРТӨГТӨХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба:

Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:

Б.ӨНӨРТӨГТӨХ
88006842

Гэрэл зургийн алба:

Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:

Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба:

Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:

М.ДАВААДУЛАМ
99042510Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн

Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Т.Булган: Ногоон зээлийн сан эхний ээлжинд агаарын бохирдол руу чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ



Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ээлжит хуралдаан өнгөрсөн мягмар гарагт болсон. Энэ үеэр яригдсан нэгэн чухал асуудал бол Ногоон зээлийн санг байгуулах тухай юм. Энэ талаар БОАЖЯ-ны Ногоон хөгжил бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Булганаас тодрууллаа.

–Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлд Ногоон зээлийн санг байгуулахаар болж байна. Ногоон зээлийн санг байгуулсны ач холбогдол, зорилгын талаар товч мэдээлэл өгөхгүй юу?

–Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, мөн өнгөрсөн гуравдугаар сард батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт байгальд ээлтэй, орчны бохирдол болон дулааны алдагдлыг бууруулсан, эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон иргэн, аж ахуйн нэгжийн төсөл хөтөлбөрийг тодорхой хэмжээнд санхүүжүүлэхээр тусгасан. Тодруулбал, маш бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгох заалтууд дээрх хөтөлбөрүүдэд туссан гэсэн үг. БОАЖЯ-ны хувьд бодлогын хүрээнд 2016 онд Монголын банкны холбоотой хамтран ажлын хэсэг гарган, Ногоон зээлийн сан байгуулах чиглэлд судалгааны ажлаа эхлүүлсэн байдаг. Судалгааны ажлаа эхлүүлснээс хойш уг зээлийн сан ямар бүтэцтэй байх, зорилготой бүлэг ямар байх зэрэг бүх зүйлээ тооцолж гаргасан байгаа. Судалгааг хийхэд олон улсын байгууллагуудын дэмжлэг чухал байсан. Тэр утгаараа Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага, НҮБ-ын төрөлжсөн таван байгууллагын санаачлагаар бий болсон Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран эдгээр судалгааг хийсэн юм.

–Ногоон зээлийн сан хэдийгээр бий болж, ажил хэргийн төвшинд үйл ажиллагаагаа явуулах бол?

–Өмнө нь БОАЖЯ судалгааны ажлаа Монголын банкны холбоо, арилжааны банкууд, олон улсын байгууллагуудтай хийсэн бол одоо үүнийг бодит сан болгох чиглэлд төрийн байгууллагуудтай нэлээд сайн хамтарч ажиллаж байна. Өнгөрсөн зургадугаар сард Сангийн сайд болон БОАЖ-ын сайд Д.Оюунхорол нарын хамтарсан тушаалаар хоёр яамнаас ажлын хэсэг гаргаж, хуралдаанаа хийсэн. Уг хуралдаанаар ямар ч байсан халаалтын улирлаас өмнө Ногоон зээлийн санг байгуулах гэж ярилцсан. Эхний ээлжинд Засгийн газраас бодлогын хүрээнд гаргасан шөнийн цахилгааныг тэглэсэн боломжийг иргэд маань илүү ашиглаасай гэдэг үүднээс

цахилгаан халаагуур, дулаалтын материалыг хөнгөлөлттэй нөхцлөөр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх чиглэлд зорилтот бүлгээ тодорхойлон ажлаа эхлүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байна. Тэгэхээр халаалтын улирал эхлэхэд уг ажлын анхны сууриа тавьчихсан байна гэж үзэж байгаа. Мэдээж, энэ маань шинэ тутамд бий болж байгаа сан учраас анхнаас нь бүх нарийн судалгааг бид нухацгай хийсэн гэдгийг онцолж. Түүнээс гадна Сангийн яамтай хамтарсан ажлыг хэсэг дээр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөл орж ажиллаж байгаа. Тэр утгаараа уг сангаа тогтвортой үйл ажиллагаа явуулах чиглэлд нэлээд нарийн анхаарч ажиллаж байгаа гэж ойлгож болно.

–Аж ахуйн нэгж, байгууллагууд санал санаачилга гаргаж, төсөл хөтөлбөрүүдээ боловсруулаад санхүүжилт авч болох юм байна гэж ойлгож болох уу?

–Эхний ээлжинд утаа, агаарын бохирдол руу чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа. Ногоон зээлийн сан маань ер нь байгальд ээлтэй, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэх боломжтой.

–Зөвхөн аж ахуйн нэгжид санхүүжилт өгөх үү. Хувь хүнд чиглэсэн зээл өгөх боломж байгаа юу?

–Ногоон зээлийн сангийн нэг онцлог нь өөрийн тань хэлсэн зүйл. Өөрөөр хэлбэл, зөвхөн аж ахуйн нэгж, байгууллагууд руу хандсан бизнесийн зээл олгохоос гадна иргэн хүн авч болох зээлийн бүтээгдэхүүнийг бий болгоно гэж үзэж байгаа.

MINFO

О.Баасанхүү:
Г.Шийлэгдамба сайд
маань 60 тэрбумын
золиос болоод 5.1
жилийн ял авлаа

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга, Эрүүл мэнд, спортын сайд асан Г.Шийлэгдамбад Эрүүгийн хуулийн 268.2 буюу бусдаас хээл хахууль авсан зүйл ангиар 5.1 жил хорих ял оноох шийдвэр гаргасан билээ. Тэгвэл энэ талаар МАХН-аас УИХ-д сонгогдсон О.Баасанхүү гишүүн өөрийн байр сууриа илэрхийлэв. Гэхдээ тэр битүү утгатай, товчлсон үг ч унагаад амжжээ. Тэрбээр гвтгтер хуудастаа “Г.Шийлэгдамба сайд маань 60 тэрбумын золиос болоод 5.1 жилийн ял авлаа. Сайдын төлбөрөө төлөх гэж яваад алдав. Н.Э дарга барлаж байгаа биз” хэмээн жиргэсэн байна. Г.Шийлэгдамба нь Эрүүл мэнд, спортын сайдын албан тушаалыг хашиж байхдаа албан өрөөндөө хахууль авч байгаад үйл дээрээ баригдан, саатуулагдаж, улмаар шүүхээс ял сонсож буй нь энэ юм.

Иргэний нисэхийн “АСЕМ” өнөөдөр эхэлнэ

Ази, Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хурал Улаанбаатар хотноо өнөөдөр эхэлж байна. Уг хурал энэ сарын 11-ийг хүртэл үргэлжлэх бөгөөд хуралд Ази, Номхон далайн бүсийн 50 орчим орон, иргэний нисэхийн олон улсын 12 байгууллагын 500 гаруй төлөөлөгч оролцож байгаа юм. Ази, Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын

54 дүгээр хурал (DGCA 54) манай улсад зохион байгуулагдсанаар Монгол Улсын нэр төрийг олон улсын тавцанд өргөх, Иргэний нисэхийн салбарыг олон улсад сурталчлах, Ази, Номхон далайн бүсийн орнуудын хоорондын хамтын ажиллагааны цар хүрээг өргөтгөх, Иргэний нисэхийн олон улсын байгууллагатай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж албаны эх сурвалж онцолсон юм.

ҮЗЭЛ ОДОЛ



ЕРӨНХИЙЛӨГЧ ӨӨ, ЭНЭ ЭРЧЭЭЭРЭЭ АЖИЛЛААРАЙ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Цаашид ч тэгэх байх. Бидэнд шийдвэртэй ажил, зоригтой шийдэл хэрэгтэй байна. Ерөнхийлөгч мөн салбарын сайдууд, Монголбанкны удирдлага, ОУВС-гийн төлөөллийг хүлээж авч уулзсан. Тэр дундаас анхаарал татахаар нь ОУВС-гийн төлөөлөлтэй хийсэн уулзалт байсан. Тэдэнд Монгол шиг баялаг ихтэй, нөөц бололцоо сайтай оронд бол 5.5 тэрбум ам.доллар тийм ч их мөнгө биш гэдгийг хэлсэн. Дээрээс нь нүүрсний үнэ багахан өсөж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлт биш гэдгийг тэдэнд сануулсан. Мөнхүүдийн мөнгө бол халамж биш. Цөөн хүн амтай Монгол Улсад ганц ч болов хэрэгжүүлж буй өсөлт рүү чиглэсэн бодлого гэдгийг ч сануулаад авсан юм. Тэр зангаргагтай байж чадаж байна. Монгол Улсын Засгийн газарт зөвлөж байгаа хүмүүст зөвлөгөө өгсөн. Тэд нэгийг бодож, хоёрыг тунгаасан байх. Харин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнтэй хийсэн уулзалтыг нь зарим хүмүүс сугалж аваад, муучлах шинжтэй байна. Төмс, хүнсний ногоог гаднаас оруулахаа больж, дотоодоос 100 хувь хангах асуудлыг шийдэж, аж ахуйн нэгжүүдээ дэмжиж ажиллах хэрэгтэй байна гэж сайдад сануулсныг нь барьж аваад л байх юм. Өөрөө сайд байсан, тэр үедээ хийхгүй яасан юм

гэж ирээд л. Мэдээж сайдаар ажиллаж байсан, энэ асуудлыг шийдэх гэж тодорхой хэмжээнд зүтгэсэн. Ажилласан хугацаа нь багахан. Хэрвээ П.Сэргэлэн сайд Засгийн газар уначихгүй л бол дахиад овоо хэдэн жил энэ салбарыг удирдах байх. Тийм болохоор монголчууд бид өөрийнхөө улсын хөрсөнд ургуулсан төмс, хүнсний ногоог идэх боломжийг хангаж өгөх хэрэгтэй. Ер нь дотооддоо бид аливаа зүйлийг үйлдвэрлэж, хэрэгцээгээ хангах зорилгыг тавих ёстой. Ядаж л хүнснээсээ эхэлж л дээ, энэ чинь. Хамгийн цэвэр, органик хүнснийг бид хэрэглэж байгаа. Тийм байтал хамгийн их хиймэл, хортой, цэвэр биш хүнснийг гэгддэг өмнөд хөршөөс болоод бусад улсаас зөөгөөд байх шаардлага юу байна. Одоо бид гадаадаас зөөж биш эх орондоо үйлдвэрлэх цаг болсон. Дэлхий аль хэдийнэ үйлдвэржилтээс халиад хиймэл оюун ухаан хүртэл хийж, сансарт жуулчлал байхад бид хүнсний ногоо зөөхөө болих гэж яриад сууж байгаа нь эмгэнэл биш үү. Тэгээд хамгийн хортой, муу хүнсийг гаднаас зөөж байж таарахгүй. Энэ талаас нь харвал Ерөнхийлөгч зөв л санаачилга гаргалаа. Заавал муу талаас нь харлуулах гээд байх шаардлага юу байна. Түүний Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх үеэсээ эхлээд л анхаарсан нэг асуудал бол МАН-ын удирдлагуудын 60 тэрбумар төрийн албыг наймаалцсан хэрэг. Дээрээс нь оффшор

бүсэд байгаа мөнгийг эх орондоо оруулж ирэх асуудал бий. 60 тэрбумтай холбоотой асуудлыг шалгахыг АТГ-ын дарга Х.Энхжаргалыг хоёр ч удаа дуудаж уулзан, даалгалаа. Эхний уулзалт дээр АТГ-ын дарга хууль дүрэмхэн яриад өнгөрсөн. Дараагийн уулзалт арай өөр болж өнгөрсөн. Асуудлыг шалгах аар болж, ажлын хэсэг байгуулсан. Манайхаас өөр оронд, хууль хяналтынхан нь улстөрчдийнхөө атгад орчихсон, гарынх нь үзүүрээр хөдөлдөггүй улсад бол энэ хэрэг аль хэдийнэ шийдэгдчихсэн байгаа. Угаасаа бүх зүйл нь тодорхой байна. Анх МАХН-ын генсек Э.Эрдэнэжамьян 60 тэрбумын бичлэгийн зах зухаас дэлгэсний дараа Ц.Сандуй яаран мэдэгдэл хийж, “Манай намынхны сонгуулийн тактик, төлөвлөгөөгөе ярих үеийн бичлэг алдагдсан байна билээ” гээд л хэргээ хүлээчихж байгаа юм. Гэтэл манай хуулийнхан огт тоосонгүй. Түүнээс хошиг маш олон нотлох баримт дэлгэгдэж, цөөнгүй хүмүүс ч ам алдсан. Гэвч хуулийнхан шалгахгүй байсаар байсан. Энэ асуудалд Ерөнхийлөгч онцгой анхаарч байгаа нь сайшаалтай. Ерөөсөө төрийн албаны суудлыг дураараа зараад байвал энэ Монгол Улс гэж оршин тогтнох аргагүй болох байлгүй. Зарим нэг хэвлэлийнхэн Ерөнхийлөгч 60 тэрбумын хэргийг Үндсэн хуулийн өөрчлөлтөөр наймаалцаж магадгүй гээд л харлуулах талаас нь

зүтгээд эхэллээ. Тийм ч юм гэж байхгүй байх. 60 тэрбумын асуудлыг шийдэж, буруутай этгээдэд хариуцлага тооцож байж Монголд цаашид шударга ёсны эхлэл тавигдана. Оффшор дансанд нуусан их мөнгийг оруулж ирж байж Монгол Улсад шударга ёс бага ч болов тогтоно. Ерөнхийлөгч 49 хоногийн хугацаа өгсөн. Тэр зууртаа АНУ-ын Элчин сайдын яамныхантай уулзаж, оффшор бүстэй холбоотой асуудалд дэмжлэг өгөхийг ч хүссэн. Хэрвээ 49 хоногт оффшор бүс дэх мөнгөө оруулж ирэхгүй бол цаашид авах арга хэмжээгээ төлөвлөд, хийж байгаа байх гэж найдаж байна. Хамгийн гол нь энэ улсад шударга ёс үйлчилж, дарга сэтгэртэй бүхэн “даам гардаг” байдлыг зогсоох цаг болсон. Энэ мэтээр Ерөнхийлөгчийн сар хүрэхгүй хугацаанд хийж, хэрэгжүүлж байгаа ажлыг дурьдаад байвал цөөнгүй байна. Хамгийн гол нь энэ эрчээ битгий алдаарай. Монголд шударга бус хэрээс хэтэрч, төрөөс төрсөн тэрбумтнууд гадаадад хаусныхаа дунд төөрч байхад энгийн иргэд орон сууц авахыг зөвхөн мөрөөдөж л сууна. Ийм байж болохгүй. Одоо энэ бүхнийг, шударга бусыг таслан зогсоох цаг болсон. Монгол Улс хөгжиж, ард иргэд нь цалинтай, орлоготой, тэгш хуваарилалтыг хүртэх эрхтэй болох цаг ирсэн. Үүний төлөө шинэ Ерөнхийлөгч зүтгээсэй. Гараанаас гарсан хурдаа битгий сааруулаарай гэж захиж гэсэн юм.

Дугаарын **60** мөр

Зам, 00-ын асуудлаа ШИЙДЧИХВЭЛ Ч

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тэдний нэг адил энэ зун Найман нуурыг зорилоо. Очиход зам нь бартаа ихтэй. Нуурынхаа урд даваан дээрээс доошоо буухад хэцүү. Жижиг машинтай бол нуурынхаа эрэг дээр очилтгүй юм билээ. Том жийтэй хүүмүүс нь л даваа давж уруудаад, нуурынхаа эрэгт очих юм. Гэхдээ зам нь маш хэцүү. Ганцхан машин л явах боломжтой. Машин зөрнө гэсэн ойлголт байхгүй. Нуурынхаа эрэгт очоод бие засах газар байхгүй. Ганц амралтын газар байгаа нь бие засах газартай л юм билээ. Гэхдээ тэнд буудаллаагүй хүмүүст хамаагүй. Ингээд л очсон иргэд ой мод руу нь ороод, хаа сайгүй бааж, шээгээд, 00-ын цаасаа хаячихсан. “Хүний аргал”, урт урт 00-ын цаасаар л нуурын хажуугийн ой мод дүүрчихэж. Очсон иргэдийн буруу гэж хэлж болохгүй. Байгалийн сайхныг тольдох гээд л очиж байгаа.

эмэгтэйгээрээ орчихдог 00 байхад яах вэ дээ. Тэгээд зам дээрээ нэг пост гаргаад, машин бүрээс 20 мянган төгрөг хураачих хэрэгтэй. Түүгээрээ нэг байгаль хамгаалагч цалинжуулаад, нуурын ойр орчмыг харж хандуулж, аялагчдад шаардлага тавиулж, хог шороог нь цэгцлээд байхад болохгүй юмгүй. Бас тодорхой хэдэн төгрөгийг нь сум орон нутгийн төсөв рүү татсан ч болно. Дээрээс нь замаа үе үе хэдэн арчлаад байхгүй юу. Ингэж л аялал жуулчлалыг хөгжүүлээр байна. Бүр цаашилбал Баг-Өлзий сум талаасаа Найман нуур руу ирдэг аятайхан замтай ч болчихмоор юм билээ. Тэгээд бас хураамжаа аваад, 00-ын асуудлаа шийдээд явчихвал аялын маш гоё маршрут болмоор санагдсан. Одоо бол Найман нуур, Улаан цутгалан гээд морьтой аятай маршрут байсан. Гэхдээ тэр болгон хүн морьтой яваад байж чадахгүй. Тийм болохоор замыг нь аятайхан засчихмаар байна.

Ямар бие засахгүй байлтай биш. Тийм болохоор Уянга сумын удирдлагууд энэ асуудалд жаахан анхаарал хандуулах хэрэгтэй байна. Найман нуурыг жишээ болгож байгаа болохоор Уянга сумын удирдлагууд гэж дурьдаж байгаа юм. Юуны өмнө хөрөнгө мөнгө шийдээд, Найман нуур хүрэх замыг сайхан засаад, сайжруулсан болгочихмоор юм билээ. Ямар засмал зам тавих гэж байгаа биш жигтэйхэн их хөрөнгө мөнгө орж юу шалиа аж. Тэгээд даваа уруудсан замыг хусаад, хоёр машин зөрөхөөр болгоод, янзалчихмаар юм билээ. Дээрээс нь нуурын эргэ хавиар 3-4 бие засах газар баримаар байна. Боловсон 00 барьж чадахгүй байж болно. Аятайхан, цэвэрхэн, дөрвөн хаалгатай, эрэгтэй,

Ингэж л бодлогоор аялал жуулчлалыг хөгжүүлбэл дотоодын жуулчдаас олсон орлогоороо л сум, орон нутаг хөгжих боломж бас байна. Цаашидад гадаадын жуулчдын ч Монголыг харах өнцөг өөрчлөгдөнө, ам сайтай болно. Тэр хэрээрээ жуулчдын тоо нэмэгдэнэ. Хаа газрын сум, орон нутгийн удирдлагууд нийм л ажлыг санаачлаад хийгээд, хөрөнгө оруулалтыг нь олчих сэтгэлтэй, чадвартай байх хэрэгтэй байна. Ядаж л сайжруулсан зам тавьдаггүй юм гэхэд том чулууг нь зайлуулаад, хуусыг нь зайлуулаад, хуусыг хэрэгтэй шүү дээ. Тэгээд хэдэн төгрөгийн хураамж аваад, тэр хөрөнгө оруулалтаараа дараа дараачийнхаа ажлыг хийсэн ч болно. Бид өөрсдөөсөө эхлээд л аялал жуулчлалаа хөгжүүлээр байна.

ЭМГЭНЭЛ



Тангадын Тогтоохүү (1943-2017)

Тангадын Тогтоохүү 2017 оны 8 дугаар сар 02-ны өдөр өвчний улмаас таалал төгсч бидэнд нөхөж баршгүй гарз тохиолоо.

Т.Тогтоохүү нь Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Багануур хэмээх газарт 1943 онд Тангадын 5 дугаар хүү болж төрсөн.

1953-1963 онд Завхан аймгийн 10 жилийн дунд сургууль

1963-1969 онд ЗХУ (хуучнаар) Эрхүү хотын Политехникийн дээд сургууль

1969-1979 онд Барилга, барилгын материалын үйлдвэрийн яам (ББМУЯ), Зам гүүрийн трестэд инженер, хэлтсийн дарга, анги, конторын дарга

1979-1981 онд МАХН-ын Төв хороонд авто зам харууцсан зааварлагч

1981-1989 онд Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газрын орлогч дарга, Нэгдүгээр орлогч дарга

1989-1994 онд Монгол улсаас ЗХУ-д суугаа ЭСЯ-нд зөвлөх

1994-1998 онд “Монгол Орос зам ХХК”-ны захирал

1998-2013 онд “Монгол элс ХХК” захирлаар ажиллаж байв.

Монгол Улсын авто замын салбарт түүний оруулсан хөдөлмөр зүтгэлийг төр засгаас өндөрөөр үнэлэн Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын 50,60,70,80,90-н жилийн ойн медалиудаар тус тус шагнаж байжээ.

Талийгаачийн шулуун шударга, ажилч хичээнгүй, нөхөрсөг зан чанар бидний сэтгэл зүрхэнд үүрд дурсагдах болно.

Түүний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд, ах дүү хамаатан садан, найз нөхөд нь гүн эмгэнэл илэрхийлжээ.

Ум сайн амгалан болтугай.

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын авто замчдын холбоо, Авто замчдын ахмадын хороо

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг үргэлжилнэ

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэгч баг буюу УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаныхан энэ сарын 04-нд Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд ажиллаж, нэмэлт өөрчлөлтийн төслийг төрийн албан хаагч, иргэдэд танилцуулж, хэлэлцүүлсэн бол 05-нд Төгрөг суманд ажиллалаа. Хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Төрийн алба, Шүүх эрх мэдэл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага гэсэн зургаан багц сэдвийн хүрээнд зохион байгуулж, Говь-Алтай аймгийн Алтай, Баян-Уул, Бугат, Дарви, Халиун, Хөхморьт, Төгрөг, Тонхил, Цээл, Шарга сумдын ИТХ, ИНХ, ЗДТГ-ын 102 албан хаагч оролцжээ. Төсөл хэлэлцүүлэгч баг танилцуулга хийсний дараахуулийн төсөлтэй холбогдуулан оролцогчдын сонирхсон асуултад хариулан санал, бодлыг нь сонссон байна. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаархи хэлэлцүүлэг өнөөдөр Говь-Алтай аймгийн Дэлгэр суманд үргэлжилж байна.

Оффшорын асуудлаар олон улстай хамтран ажиллах тухай Сангийн сайдад хандав

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд оффшорын асуудлаар олон улсын байгууллагатай хамтрах асуудлаар Сангийн сайдад хандан албан бичиг хүргүүлжээ. Уг албан бичигт “Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга манай улсаас оффшор бүсэд хууль бусаар байршуулсан хөрөнгийг буцаан авчирч өрийн дарамтыг багасгах чиглэлээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын /OECD/ оффшор бүсэд хууль бусаар хөрөнгө байршуулахын эсрэг үйл ажиллагаа явуулдаг Татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны

чиглэлээрх Дэлхийн форум /Global Forum of Transparency and Exchange of Information for Tax Purposes/ мөн татварын шударга тогтолцоог бүрдүүлэх Татварын суурийг багасгаж ашгийг зувчуулах /Base Erosion and Profit Shifting/ асуудлыг эрэг төсөлтэй хамтран ажиллахаар төлөвлөж байгаа юм. Эдгээр байгууллагуудаас гишүүн болох саналыг 2012, 2016 онуудад манай талд тавьж байсан байна. Оффшор бүсэд хууль бусаар хөрөнгө байрших явдалтай тэмцэх ажлын хүрээнд эдгээр байгууллагуудад Монгол Улс нэгдэн орох асуудлыг судлан үзэж хэрэгжүүлэхээр ажиллана уу. Явцыг эргэж мэдээлэхийг хүсье” гэжээ.

Ерөнхий сайд Солонгос Монголын хамтын ажиллагааны форумын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Монгол-Солонгосын эдийн засгийн форум, Солонгос-Монголын хамтын ажиллагааны форумын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Монгол Солонгосын эдийн засгийн форум хоёр улсын харилцаа хамтын ажиллагааг бүхий л түвшинд эрчимтэй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зургаан жилийн өмнө байгуулагдсан, үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаг бөгөөд хамтарсан хуралдаан нь өнөөдөр Улаанбаатар хотноо эхэлж буй юм байна. Уулзалтад тус форумын удирдах зөвлөлийн гишүүн, УИХ-ын гишүүн Н.Энхболд, удирдах зөвлөлийн дэд дарга Г.Батхүү, Солонгос-Монголын

хамтын ажиллагааны форумын тэргүүн, БНСУ-ын Үндэсний ассамблейн гишүүн Ким Тэ Нён, БНСУ-д суугаа Элчин сайд Б.Ганболд, Монгол Улсад суугаа Элчин сайд У.Сун болон форумын бусад гишүүд оролцсон юм. Уулзалтын үеэр хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, Солонгост ажиллаж амьдарч буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах болон тус улсаас манай улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд форумаас үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагааны талаар ярилцлаа. Монгол, Солонгосын харилцааг бүхий л салбарт хөгжүүлэхийн төлөө гүүр болж ажилладагт Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат талархал илэрхийлээд хамтарсан хуралдаанд амжилт хүсье.

ДЭЛХИЙ

НУБ ХОЙД СОЛОНГОСЫН ЭСРЭГ ХОРИГОО ЧАНГАТГАЖ, Ш.АБЭ ЗАСГИЙН ГАЗРАА ШИНЭЧИЛСЭН 7 ХОНОГ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт


Мөн тус улсын гадаад худалдааны банкны дансыг царцааж, тэнгисийн цэргийн хөлөг онгоцдыг нь бүх улсын боомт руу орохыг хориглосон байна. Түүнчлэн, энэ шийдвэрийн хүрээнд НУБ-ын гишүүн орнууд нутаг дэвсгэртээ Хойд Солонгосын ажилтнуудын тоог нэмэхгүй байх, тус улсын үйлдвэрүүдийг нь өргөжүүлэхгүй байх, шинээр хамтарсан үйлдвэр барихгүй байх үүрэг хүлээлээ. Пхеньян дээр дурьдсан ашигт малтмалын экспортоосоо жилд гурван тэрбум ам.долларын ашиг орлого олдог байна. Харин хориг арга хэмжээ хэрэгжиж эхэлснээр, жилийн орлого нь тэрбум орчим ам.доллаароор буурна гэж тооцжээ. Энэ жилийн нэгдүгээр сард Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр томилогдсоноос хойш Пхеньяны эсрэг хориг арга хэмжээг анх удаагаа чангатгаж буй нь энэ юм. БНХАУ ч холбоотон Хойд Солонгос улсын эсрэг хоригийг биелүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлээд байна.

Өнгөрсөн сарын 4-нд Пхеньян тив алгасагч баллистик пуужингийн туршилт хийсэнтэй холбоотойгоор АНУ тус улсын эсрэг дахин шинэ хориг тавих талаар БНХАУ-тай хэлэлцээр хийж эхэлсэн байдаг. Гэтэл үүний дараа буюу мөн сарын 28-нд ч Пхеньян дахин тив алгасагч пуужин туршсан юм. Тиймээс НУБ-ын Аюулгүйн зөвлөл цөмийн зэвсгийн хөгжүүлэлтийн эсрэг тэмцлийн арга барилдаа дахин шинэчлэхэд хүрчээ. НУБ дахь АНУ-ын төлөөлөгч Никки Хале "Хойд Солонгос баллистик пуужин туршсантай холбоотойгоор тус улсын эсрэг авсан хориг арга хэмжээгээ чангатгаж, шинэ шатанд аваачихад хүргэсэн. Энэ удаагийн шийдвэр Ким Жон Унд анхааруулга болох байх" гэж хэвлэлд ярьсан байна. НУБ-ын Аюулгүйн зөвлөлийн гишүүд 100 хувь хориг арга хэмжээг чангатгахад санал нэгдсэний дараа Хале "Энэ удаагийн шийдвэр сүүлийн жилүүдэд авсан хориглоос хамгийн чанга нь" гэдгийг онцолжээ.

НУБ-ын гишүүн орнууд хоригийг хэрэгжүүлснээр, баллистик пуужин, цөмийн зэвсгийн хөгжүүлэлтээ үргэлжлүүлж буй Хойд Солонгос улсын эдийн засагт ноцтой үр дагавар учруулна гэж шинжээчид тооцож байна.

Шинзо Абэ гурав дахь Засгийн газраа байгууллаа

Дуулиан шуугиантай холбоотойгоор Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг сэргээх зорилгоор Японы Ерөнхий сайд Шинзо Абэ танхимдаа шинэчлэлт хийв. Тэрбээр 19 сайдынхаа 14-ийг нь шинээр томилон, бүрэлдэхүүнийг баталжээ. Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн тухайд гурав дахь удаагаа Засгийн газрынхаа сайд нарыг огцруулан шинээр томилж буй нь энэ юм. Энэ удаагийн халаа сэлгээгээр түүний ойрын нөхөд гэгддэг Сангийн сайд Таро Асо, Сайд нарын танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Ёшихидэ Суга, Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн сайд Хирошигэ Сэко нар албан тушаалдаа хэвээр



...Д.Трампын тухайд өмнөх Ерөнхийлөгч Барак Обамаг амралтаа авахад нь шүүмжилж, өөрөө хэрэв Ерөнхийлөгч болбол амрахгүй хэмээж байсан ч, эхний жилдээ 17 хоногийн амралт авсан нь хэвлэлийнхний шүүмжлэлд өртсөн. Гэсэн ч, Цагаан ордноос "Ерөнхийлөгч ажиллангаа амарсантай ялгаагүй" гэж тайлбарласны зэрэгцээ Вашингтон ДС хот дахь Ерөнхийлөгчийн ордны баруун жигүүрийн агааржуулалтын системийг шинэчлэхээр болсныг мэдэгджээ. 2012 онд Трамп твиттер хуудастаа "Ажил чинь уйтгартай санагдаж байвал, тохирохгүй л байна гэсэн үг дээ" хэмээн жиргэн шүүмжилж байсан юм...

үлдсэн байна. Харин шинээр Гадаад хэргийн сайдаар Таро Коно томилогджээ. Таро Коно 2015-2016 онуудад тус яамны захиргааны шинэчлэлт, нийтийн аюулгүй байдлын асуудлыг хариуцан ажиллаж байжээ. Харин баримт мэдээллийг нуун дарагдуулсан гэх дуулианаар шинэчлэлт хийв. Тэрбээр 19 сайдын суудалд Ицунори Нонодэрэ дахин томилогдсон байна. Тэрбээр 2012-2014 онд энэ албан тушаалд ажиллаж байжээ. И.Онодэрэ нь Японы батлан хамгаалах хүчнийг зузаатгах бодлого баримталдаг улстөрч юм. Засгийн газрын голлох албан тушаалын нэг болох Захиргааны хэргийн сайдаар Японы Либерал ардчилсан намын Ерөнхий зөвлөлийн дарга асан Сэйко Нода томилогдсон бол Эдийн засгийг сэргээн босгох яамны



сайдаар Эдийн засгийн яамны тэргүүн асан Тосимицу Мотэги нар тус тус томилогдсон байна. Түүний шинээр бүрдүүлсэн гурав дахь удаагийн Засгийн газар хоёр эмэгтэй сайд багтжээ. Тэдний нэг нь Сейко Нода. Тэрбээр шинэ Засгийн газарт Дотоод хэрэг, харилцаа холбооны сайдаар томилогдсон нь хамгийн их анхаарал татсан томилоо байсан юм. Нода сайд болсныхоо дараа 2018 оны эрх баригч намын даргын сонгуульд нэр дэвшинэ гэдгээ ч илэрхийлээд амжсан. Мөн нэг сонирхолтой мэдээлэл байгаа нь Сейко Нода Токиогийн парламентын сонгуульд ялалт байгуулсан сөрөг хүчний лидер Юрико Койкэгийн дотны найз гэнэ.

Ямартай ч, Шинзо Абэгийн Засгийн газрын шинэчлэлт, халаа сэлгээний дараа ард иргэдийн итгэл сэргэж эхэлсэн дүн гарчээ. Тухайлбал, "Кёодо" агентлагийн явуулсан санал асуулгад оролцогчдын 44.4 хувь нь Засгийн газрын шинэчлэлийг эергээр үнэлсэн байна. Өмнө нь сайд нарын танхимын үйл ажиллагааг дэмжигчдийн хувь 35 хүртлээ унасан байсан юм. Мөн сайдуудын томилоог 55 хувь нь дэмжиж буйгаа илэрхийлжээ.

В.Путин, Д.Трамп нар амралтаа авлаа

Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа хамгийн их анхаарал татсан үйл явдал нь дэлхийн хүчирхэг хоёр гүрний төрийн тэргүүнүүдийн зуны амралт байлаа. АНУ, ОХУ-ын төрийн тэргүүнүүд өнгөрсөн долоо хоногтоос эхлэн амралтаа авсан юм. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп энэ сарын 4-нөөс эхлэн 17 хоногийн амралт авч, Нью-Жерсимужийн Бедминстер дэх өөрийн эзэмшлийн гольфын резорт руугаа явсан бол ОХУ-ын төрийн тэргүүн В.Путин Сибирийн Тувад загасчлан амарчээ. Түүнтэй хамт тус улсын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу нарын сайд нар амарсан байна. Д.Трампын тухайд өмнөх Ерөнхийлөгч Барак Обамаг амралтаа авахад нь шүүмжилж, өөрөө хэрэв Ерөнхийлөгч болбол амрахгүй хэмээж байсан ч, эхний жилдээ 17 хоногийн амралт авсан нь хэвлэлийнхний шүүмжлэлд өртсөн. Гэсэн ч, Цагаан ордноос "Ерөнхийлөгч ажиллангаа амарсантай ялгаагүй" гэж тайлбарласны зэрэгцээ Вашингтон ДС хот дахь Ерөнхийлөгчийн ордны

баруун жигүүрийн агааржуулалтын системийг шинэчлэхээр болсныг мэдэгджээ. 2012 онд Трамп твиттер хуудастаа "Ажил чинь уйтгартай санагдаж байвал, тохирохгүй л байна гэсэн үг дээ" хэмээн жиргэн шүүмжилж байсан юм. Гэхдээ Вашингтон пост сонинд бичсэнээр тэрбээр тангаргаа өргөснөөсөө хойш наймдугаар сарын сүүлч хүртэл Трамп 53 өдөр амрах бол өмнөх төрийн тэргүүн Барак Обама 2009 онд ердөө 15 хоног л амарч байжээ. АНУ-ын төрийн тэргүүний тухайд ийнхүү өмнө нь хэлсэн үгнээсээ болж шүүмжлэлд өртсөн бол ОХУ-ын Ерөнхийлөгчийн амарч буй зурагнууд олны анхаарлыг татсан юм.

2028 оны олимпын бамбар Лос-Анжелест асна

Лос-Анжелес хот Олон улсын олимпын хороотой тохиролцоонд хүрснээ өнгөрөгч даваа гарагт зарласан. Тус шийдвэрийн дагуу 2024 оны олимп Францын нийслэл Парис хотноо, харин 2028 оны олимпын бамбар АНУ-ын Лос-Анжелес хотод асах

нь тодорхой боллоо. 2020 оны олимп Японы нийслэл Токио хотод болно. Харин 2024 болон 2028 оны олимпын наадмыг аль улс зохион байгуулахыг ОУОХ хамтад нь тодруулсан нь тодорхойгүй нөхцөл байдал үүсгээд байв. Угтаа 2024 оны олимпыг зохион байгуулахаар АНУ болон Европын хэд хэдэн хот саналаа өгсөн байдаг ч, Лос-Анжелес, Парис хоёр үлдсэн. Гэвч, Парис өмнө нь хэдэнтээ санал өгөөд татгалзсан харуу авч байсан учир цаашид өрсөлдөхгүй гэдгээ мэдэгдсэнээр талууд тохиролцон Лос-Анжелес 2028 оны олимпыг зохион байгуулахаар болсон байна. Хэрэв хоёр хот тохиролцоонд хүрээгүй бол аль нь эхэлж 2024 оны Олимпын тоглолтыг зохион байгуулах вэ гэдгийг энэ оны есдүгээр сард Перу улсын нийслэл Лима хотод болох ОУОХ-ны 131 дүгээр чуулганы үеэр тодруулах байжээ. Парис болон Лос-Анжелесын хувьд өмнө нь тус бүр хоёр удаа Олимпын наадмыг зохион байгуулж байсан туршилагатай хотууд. Тодруулбал, Парис хот 1900 болон 1920 онд Олимпыг хүлээн авч байсан бол Лос-Анжелес хот 1932 он болон 1984 онд Олимпын наадам зохион байгуулж байжээ.

"Daesang" брэндийн бүтээгдэхүүн танилцуулах өдөрлөг боллоо



БНСУ-ын "Daesang" брэндийн бүтээгдэхүүн танилцуулах өдөрлөг "Чингис хаан" зочид буудлын "Тэмүүжин" ресторанд боллоо. "Emart" сүлжээ дэлгүүр Монголд нээлтээ хийсний нэг жилийн ой долдугаар сарын 28-нд тохиожээ. Ойн хүрээнд БНСУ-ын "Daesang" үйлдвэр хамтын ажиллагааны хүрээнд энэхүү арга хэмжээг зохион байгуулав. Бүтээгдэхүүн танилцуулах өдөрлөгөөр "Daesang" брэндийн бүтээгдэхүүнийг "Emart" дэлгүүрийн үйлчлүүлэгчдэд танилцуулах болон солонгос хоолыг гэртээ хялбар аргаар хийх аргачлалыг иргэд, үйлчлүүлэгчдэд зааж,

сурталчиллаа. Тус брэндийн хоолны бүтээгдэхүүний хөгжлүүлэлт хариуцсан, судлаач, тогооч Шин Сү Гён өдөрлөгт хүрэлцэн ирсэн үйлчлүүлэгчдэд таван төрлийн солонгос хоолыг гэрийн нөхцөлд "Daesang" брэндийн

бүтээгдэхүүнээр хэрхэн амталж, хялбар аргаар хийх аргыг зааж, сонирхуулав. "Daesang" брэндийн бүтээгдэхүүн Монголд нийлүүлэгдээд 17 жил болж буй бөгөөд 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн нь Монголын зах зээлд

борлуулагдаж байна. "Daesang" үйлдвэр нь бүтээгдэхүүнээ "Emart" сүлжээ дэлгүүрт албан ёсоор нийлүүлж байгаа тул тус брэндийн бүтээгдэхүүнийг "Emart" сүлжээ дэлгүүрээс худалдан авах боломжтой болжээ.



ХУЧИНГҮЙД ТООЦОВ

- Ванжиндолгор овогтой Үүрийнтуяагийн эзэмшлийн ГО918001122 улсын бүртгэлийн дугаартай, 000117258 гэрчилгээний дугаартай хашаа байшингийн гэрчилгээ гээгдүүлсэн тул
- Батжаргал овогтой Галсангийн УГ59051011 регистрийн дугаартай, 239 дугаар бүхий газар эзэмшлийн гэрчилгээ гээгдүүлсэн тул тус тус хүчингүйд тооцов.

ОНЦЛОХ ХУУДАС

ХЭНИЙГ НЬ ЗОЛИОСЛОХ ГЭЭД БАЙНА ВЭ?

Эсрэг тэсрэг байр суурь

Ж.Эрдэнэбат:
Миний эрхэлж буй албан тушаалын байдлыг үл харгалзан бодит үнэнийг тогтоож өгнө үү



/Монгол Улсын Ерөнхий сайд/

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Цагдаагийн байгууллагад өөрийгөө болон иргэн н.Энхмэнд, н.Золбаяр нарыг шалгуулахаар энэ сарын 03-нд гомдол гаргасан тухай мэдээлэл цацагдав. Тодруулбал, өчигдрөөс эхлэн сошиал орчинд н.Энхмэнд, н.Золбаяр нарын хүмүүс “Би Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын даалгавраар У.Хүрэлсүхийг өдөж, зодоон үүсгэхийн тулд хэд хоног дагасан” гэсэн мэдэгдэл бүхий бичлэг цацагдсан. Энэхүү мэдээллийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат нэр төрд нь халдах гэсэн бусдын зохион байгуулалттай үйлдэл хэмээн үзэж, цагдаагийн байгууллагад шалгуулахаар хандсан байна.

Тэрбээр ЦЕГ-ын дарга Ө.Энхтөрд хандан гаргасан гомдолдоо “Сошиал буюу интернэт орчныг ашиглан бусдыг гүтгэн доромжлох, нэр хүндийг нь унагаан харлуулах, зохисгүй үзэгдэл хэрээс хэтэрч байгааг хууль хяналтын байгууллага анхааралдаа авах шаардлага бий болжээ. Иргэдийн интернэтийн хэрэглээ өргөжихийн хэрээр энэ мэт саар үзэгдэл газар авч, улмаар хэсэг бүлэг хүмүүс зөвхөн дээрх зорилгоор нэгдсэн зохион байгуулалтад орсон нь нууц биш болжээ.

Өчигдөр буюу 2017 наймдугаар сарын 02-ны өдрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сайтуудыг ашиглан ашиглан миний биенийг зохион байгуулалттайгаар Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийг танхайн гэмт хэрэг үйлдсэн мэтээр харагдуулах зорилготой ажиглагааг бусдад захиалга өгч гүйцэтгүүлсэн мэт дуу, дүрс бүхий бичлэгийг тараасан байна. Уг бичлэг, дуу оруулалт, монтаж, найруулга, зохиол бүхий байгаа нь тодорхой хөрөнгө шаардсан нарийн зохион байгуулалт бүхий ажил болох нь харагдаж байна.

Миний ажил хэргийн болоод хувь хүний нэр төр, алдар хүндийг олон нийтэд гутаан доромжлох зорилготой энэхүү үйл ажиллагаа нь тухайн бичлэгийн зохиомол байдлаар хязгаарлагдсан, эсхүл үнэхээр дүрс бичлэгт нэр дурьдагдсан нэр бүхий хүмүүс болох н.Золбаяр, н.Энхмэнд гэх хүмүүсийн оролцоотойгоор хийгдсэн бодитой, зохион байгуулалттай ажиглагаа юу гэдэг асуудал, түүний үнэн мөнгийг олж тогтоох нь чухал байна.

Дүрс бичлэгт байх гэрч нарын мэдүүлэгт нэр дурьдагдсан н.Энхмэнд, н.Зол-Эрдэнэ нарын хүмүүс өмнө нь Тагнуулын байгууллагад ажиллаж байсан, гүйцэтгэх ажлын туршлага, мэдлэг бүхий хүмүүс байгааг шалгалтын ажиглагаандаа онцгой анхаарч үзэх шаардлагатай байна.

Иймд дараах асуудлуудыг шалгуулах хүсэлтэй байна. Үүнд:

1. Уг бичлэгийг зохион байгуулалттай, урьдаас төлөвлөж, найруулж, монтаж, дуу оруулалт, тайлбар бүхий зохиомжилсон нь нэгэнт тодорхой байна. Иймд дүрс бичлэгийг хэний захиалгаар, хэн, хэзээ хийсэх болох;
2. Дүрс бичлэгт дурьдагдсан үйл явдал үнэхээр болсон эсэх, үнэхээр дээрх зохион байгуулалт бүхий ажиглагаа явагдсан бол үүнийг хэний захиалга, хүсэлтээр гүйцэтгэсэн болох, ямар учраас миний биенийг хамаатуулсан болох зэргийг богино хугацаанд нэг мөр шалгаж, тогтоолгох хүсэлтэй байна.

Дээрх үйлдлийг бүхэлд нь дүгнэн үзвэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлгийн 20.3 дахь хэсэгт заасан “Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх” гэмт хэргийн шинжтэй байгааг анхаарна уу.

Миний бие өөрийн гаргасан гомдолд дурьдсан асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд биечлэн тайлбар, мэдүүлэг өгөх, баримт сэлт гаргах зэргээр иргэнийхээ хувьд эрхээ эдэлж, үүрэг хүлээж оролцох бөгөөд та бүхэн шалгалтын ажиглагааг миний эрхэлж буй албан тушаалын байдлыг үл харгалзан шударгаар явуулж, бодит үнэнийг тогтоож өгнө гэдэгт найдаж байна” хэмээжээ.

...Миний бие өөрийн гаргасан гомдолд дурьдсан асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд биечлэн тайлбар, мэдүүлэг өгөх, баримт сэлт гаргах зэргээр иргэнийхээ хувьд эрхээ эдэлнэ...

...Шадар сайдын ажлын алба мэдэгдэж байгаа. Энэ хэрэг явдлыг хууль хяналтын байгууллага шалгаж байгаа учраас сэтгүүлчдийн асуултад хариулт өгөх боломжгүй байгаа гэдгийг хэлье...



А.Үйлстөгөлдөр:
Шадар сайд У.Хүрэлсүхтэй холбогдох хэргийг хууль хяналтын байгууллага шалгаж байгаа

/Шадар сайдын зөвлөх/

Дээрх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн Ажлын албанаас мэдээлэл

хийлээ. Энэ үеэр Монгол Улсын Шадар сайдын Ажлын албаны дарга Б.Энх-Амгалан “Өчигдрөөс эхлэн мэдээллийн сүлжээгээр У.Хүрэлсүхийг мөрдсөн талаар асуудал гарч ирлээ. Харамсалтай нь нийм явдал болсон нь үнэн. Бид 2017 оны долдугаар сарын 3-ны өдөр Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газарт хандсан. Шадар сайдын хувьд энэ асуудалд нухацтай хандах үүрэг өгсөн. Энэ асуудал одоо шалгагдаж байна” гэсэн юм. Харин уг ажлын хэсгийн ажлагч А.Үйлстөгөлдөр “Сарын өмнө бидэнд Шадар сайд У.Хүрэлсүхийг хууль бусаар мөрдөж эхэлсэн тухай мэдээлэл ирсэн. Энэ асуудлыг Шадар сайдад танилцуулахад “Хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй” гэж үзсэн. Ийм учраас долдугаар сарын 03-нд Тагнуулын ерөнхий газрын дарга Б.Хурц, Авлигатай тэмцэх газрын дарга Х.Энхжаргал нарт хандан албан бичиг хүргүүлсэн. Албан бичигт “Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн амь нас, эрүүл мэндэд халдах зохион байгуулалттай үйл ажиллагааг нэр бүхий албан тушаалтан зохион байгуулж болзошгүй гэж үзэж байгаа тул уг асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд нягтлан шалгаж, яаралтай арга хэмжээ авна уу” гэж бичсэн байгаа. Одоогоор дээрх газруудаас ямар нэгэн хариу ирүүлээгүй байна. Дөрөв хоногийн өмнө /2017.08.01/ мөн УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ж.Энхбаярт хандсан. Яагаад гэвэл энэ хэрэг явдалтай холбоотой гэх бичлэг олон нийтийн сүлжээгээр цацагдаж эхэлсэн. Албан бичигт “Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд халдахаар Монгол Улсын зарим иргэд хууль бусаар чагнах, тагнах ажиллагаа явуулж байгаа талаар Шадар сайдын албанд мэдээлэл ирүүлсний дагуу холбогдох байгууллагаар шалгаж, тогтоолгох тухай албан бичиг явуулсан. Энэ үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн, төрийн өндөр дээд албан тушаалтны амь нас, аюулгүй байдалд заналхийлсэн. Цаашлаад төрийн сайдыг тагнах, чагнах байдлаар хууль бус гүйцэтгэх ажиллагаа явуулах замаар үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах гэсэн ноцтой үйлдэл тул Аюулгүй байдлын байнгын хороонд хандаж байна. УИХ-ын Тусгай хяналтын дэд хороонд мөн хандсан байгаа. Та бүхэнд хариуцлагатай хэлэхэд энэ явдлын талаар баримт бичиг болон CD хувилбараар ирсэн нь үнэн. Энэхүү явдалд бид маш их сэтгэл зовниж байна. Энэ хэрэгтэй холбоотой гэрчүүдэд санаа зовниж байна. Хуулийн байгууллагаар аюулгүй байдлыг хангах, гэрчүүдийг хяналтдаа авах нь зүйтэй гэж Шадар сайдын ажлын алба мэдэгдэж байгаа. Энэ хэрэг явдлыг хууль хяналтын байгууллага шалгаж байгаа учраас сэтгүүлчдийн асуултад хариулт өгөх боломжгүй байгаа гэдгийг хэлье” гэсэн юм.

Сэтгүүлчийн дүгнэлт

ЭРХ МЭДЛИЙН ТӨЛӨӨ ШОУДАЖ БАЙГАА ЮМ БИШ ҮҮ

Э.ТУУЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд МАН-аас нэр дэвшин, ялагдсан УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболд өөрийн фэйсбүүк хуудастаа “2017 оны долдугаар сарын 08-ны өдрийн МАН-ын Удирдах зөвлөлийн 10 дугаар хурлаар би дараах асуудлыг оруулж хэлэлцүүлсэн. Үүнд, ард түмний сонголтгүй хүндэтгэн үзэж, шинэ ерөнхийлөгчийг наадмын өмнө тангараг өргүүлэх, Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар анализ хийж, дүгнэлт гаргах, 2017 оны есдүгээр сард намын бага хурлыг зарлан хуралдуулах, сонгуулийн үр дүнгийн талаарх дүгнэлтийг хэлэлцэх, намын их хурлыг товлон зарлах, МАН-ын ээлжит их хурлаар өнгөрсөн 27 дугаар их хурлаас хойших үр дүн, алдаа дутагдлыг авч хэлэлцэх, намын дунд хугацааны зорилго зорилтыг тодорхойлох, намын шинэ удирдлагыг сонгох, 2020 оны сонгуульд бэлтгэх ажлыг эхлүүлэх нь зүйтэй хэмээн санал оруулсныг Удирдах Зөвлөлийн гишүүд дэмжсэн болно” гэж мэдээлсэн билээ. Энэ дундаас “намын шинэ удирдлагыг сонгох” гэсэн асуудал нэлээд эрчээ авч, намын шинэ даргад өрсөлдөгчид хэдийнэ тодорчихоод байгаа сурагтай. Үүнтэй зэрэгцэн сошиал орчинд “Social News Mongolia” хэмээх хаягнаас “Анхаар!!! Маш ноцтой бичлэг... Төрийн сайд хүнийг ингэж байхад энгийн иргэн бол цаашаа юм байна...” гэсэн гарчиг бүхий видео бичлэг цацагдаж, олны анхаарлыг татсан. Учир нь уг бичлэгт гарч буй гэрч Чойжилсүрэнгийн Батболд гэгч нь “Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын даалгавраар Шадар сайд У.Хүрэлсүхийг дагаж, ямар нэг аргаар өдөж хоргоож байгаад цагдаагийн байгууллагад өргөдөл өгөх” даалгаврыг биелүүлэх ёстой байсан ч энэ ажил гэнэт таалагдахаа больсон тул нэрээ татаж, бас энэхүү бусармаг үйл ажиллагааг илчлэхээр шийдсэн гэж байгаа. Тэгвэл энэ бичлэг цацагдсаны дараахан буюу энэ сарын 03-нд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, нэр төр, алдар хүндээ сэргээлгэхээс гадна энэ жүжгийг хэн тавиад байгааг олж илрүүлэхийг хүсэв. Үнэхээр ийм хэрэг үйлдсэн бол илрүүлээд өгөөч ээ гээд зогсож байхгүй нь лавтай. Тиймээс түүнийг буруутгах үндэслэл энд алга. Энэ бол эрх мэдлийн төлөөх “жүжиг” гэдгийг эсрэг тал нь хэлээд өгчихлөө шүү дээ, бараг. Тодруулбал, Ерөнхий сайдыг хууль хяналтын байгууллагад хандаж, гомдлоо гаргаж байх зуур, тус бичлэгт нэр дурьдагдаад буй гол баатар болох У.Хүрэлсүх ажлын албаныхаа залуусыг өмнөөсөө гүйлгэж, хэвлэлийн хурал зарлуулж, амь насанд нь аюул занал учирсан мэтээр яруулаад амжив. Үнэн хэрэгтээ төрийн тусгай хамгаалалтад байх ёстой Ерөнхий сайд маань иргэний хувиар гомдлоо хууль хяналтын байгууллагад нь гаргаж өгчихөөд байхад Шадар сайдын ажлын алба нь түүний өмнө бөхөлзөөд, бичиг шидэлцээд байгаа нь утгагүй санагдана. Шадар сайд бол төрийн тусгай хамгаалалтад байдаггүй албан тушаалтан. Ямар хувийн компанийн захирал биш дээ. Өөртэй нь холбоотой асуудал гарсан юм бол хувь хүнийхээ үүднээс холбогдох байгууллагад өөрөө гомдлоо гаргаж болно оо доо, энэ чинь одоо. Гэтэл төрийн албан хаагчид дарга нарынхаа өмнүүр орж, гүйлдээд байгаа нь энэ үйл явдлыг “жүжиг” гэж харахад хүргээд байгаа юм. Бас болоогүй ээ, дээрх бичлэгийн II анги “Цензургүй үгс” гэх пэйж хуудсаар энэ сарын 05-нд “Шадар сайдад халдах “G” ажиглагааны тухай хөдлөшгүй баримтууд” гэсэн гарчигтай цацагдаж, зарим телевизүүдээр төлбөртэй гарав. Тэгэхээр энэ бичлэгийг У.Хүрэлсүхийн талаас хийж, өрөвдүүлэх тактик хэрэглэхээр шийдвэр үү хэмээн хардахад хүргээд байгаа юм. Учир нь өнөөдөр МАН дотор намын даргын суудлын төлөөх фракци хоорондын зөрчилдөөн дээд цэгтээ хүрч, халаа сэлгээ, хариуцлагын дайн өрнөж байгаа нь хэн бүхэнд тодорхой. Эх сурвалжийн мэдээлж буйгаар, МАН-ын шинэ даргад Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Шадар сайд У.Хүрэлсүх нарын нэр яригдаж байгаа гэх. Тиймээс ч У.Хүрэлсүх энэ суудал, эрх мэдлийн төлөөх их дайнаа эхлүүлээд байгаа нь энэ бололтой гэлцэх хүмүүс ч цөөнгүй болжээ. Энэ бүхнээс харахад Ерөнхийлөгчийн сонгуулийн ялагдлын улмаас сулрах албан тушаалын төлөө МАН-ын дотоод тэмцэл нэлээд хурцдах төлөвтэй. Ер нь ч тэгээд “Айсан хүн адуу хөөж, ичсэн хүн хүн алдаг”-ийн үлгэрээр энэ жүжгийн найруулагч нь тун удахгүй тодрох байлгүй дээ, хөөрхий.

МЭДЭЭЛЭЛ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2017 ОНЫ 7 ДУГААР САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ

ШИНЭЭР ОЛГОСОН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Шийдвэрийн огноо	Шийдвэр #	Олгосон огноо
1	MV-020859	Сэлэнгэ	Баянгол	Наран гол	61,71	Тайхаржин майнинг	6112633	2017.07.03	386	2017.07.03
2	MV-020861	Говь-Алтай	Тайшир	Шар тохой	144,43	Ирээдүй МНЖ транс	5550505	2017.06.23	363	2017.07.04
3	MV-020862	Булган	Бүрэгхангай	Туул	452,90	Тэргүүн майнинг	6030343	2017.07.04	391	2017.07.04
4	XV-014897	Сэлэнгэ	Баянгол	Буянт	28,64	Эм Жи Эм Жи	5576741	2017.07.06	393	2017.07.06
5	MV-020877	Увс	Бөхмөрөн	Индэрт-2	1 470,73	Тефис майнинг	2807459	2017.07.24	428	2017.07.27
6	MV-020884	Сэлэнгэ	Баянгол	Буянт	58,25	Эм Жи Эм Жи	5576741	2017.07.31	461	2017.07.31
7	MV-020885	Хөвсгөл	Цагаан-Уул	Цагаан уул	2 360,11	Монгол ресурс корпорац	5365112	2017.07.26	435	2017.07.31
8	MV-020875	Увс	Бөхмөрөн	Индэрт	794,82	Тефис майнинг	2807459	2017.07.24	425	2017.07.27
			Ховд		120,44					

ШИЛЖҮҮЛСЭН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ	Шилжүүлсэн хэлбэр	Эзэмшигч	"Эзэмшигчийн Регистр"	"Шинэ эзэмшигчийн нэр"	Шинэ эзэмшигчийн регистрийн дугаар	"Шийдвэрийн огноо"	"Шийдвэрийн дугаар"
1	MV-000129	Төв	Заамар	Ар наймган хөндий доод хэсэг	103,76	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	Эм Жи Жи И Си	5898749	2017.07.27	454
2	MV-000704	Төв	Заамар	Туул голын дэнж	369,47	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	Уулсаамаар	2819996	2017.07.24	421
3	MV-005411	Баянхонгор	Гурванбулаг	Өвөр хөшөөт	272,39	Бүхэлд нь	Жи Эс Би майнинг	5439574	Жи Эс Би Ресурс	5517176	2017.07.26	437
4	MV-013421	Увс	Тариалан	Улаан ам-1	24,84	Бүхэлд нь	Дацантрейд	2061848	Нэгэнт	4001621	2017.07.24	424
5	MV-013786	Булган	Бүрэгхангай	Сөөг	9,37	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	Платинумланд	5076285	2017.07.16	398
6	MV-013787	Булган	Бүрэгхангай	Туулын зүүн дэнж	47,74	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	Платинумланд	5076285	2017.07.16	395
7	MV-015643	Баянхонгор	Галуут	Хүүшийн ам	106,51	Бүхэлд нь	Рео	5018056	Империал гоулд майнинг	6171788	2017.07.24	423
8	MV-016752	Төв	Заамар	Баясгалантын дэнж	52,88	Бүхэлд нь	Хосбогд	5157145	Хавтгайн хангайн хүрд	6183786	2017.07.21	409
9	MV-016833	Дархан-Уул	Хонгор	Шийрийн хөндийн адаг 4-р орд	24,88	Бүхэлд нь	Дархан эрдэнэ бүрэн	2736624	Иннова Ложикстик	5718902	2017.07.21	411
10	MV-017371	Сэлэнгэ	Орхонтуул	Орхонтуул-4	1 079,62	Бүхэлд нь	Ирмүүнбосго	5396786	Бийд майнинг	6164706	2017.07.24	422
11	MV-017637	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хөхтэйн нуруу	420,24	Бүхэлд нь	Товгорхад	5113008	Гуо мао жиа хэ	6194559	2017.07.24	417
12	MV-017638	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хөхтэйн нуруу-1	362,38	Бүхэлд нь	Товгорхад	5113008	Гуо мао жиа хэ	6194559	2017.07.24	418
13	XV-017774	Завхан	Баянхайрхан	Оюут	167,86	Бүхэлд нь	Адексмайн	5876826	Эс Ти Эс Эм	5945119	2017.07.16	397
14	XV-018653	Булган	Дашинчилэн	Доргоногт, Улаан ухаа	1 563,12	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	ПЛ майнинг	5926629	2017.07.27	455
15	XV-018749	Говь-Алтай	Бигэр	Тээл	2 608,88	Бүхэлд нь	Цэнгүүншилтгэн	5861519	Цахирт өндөр майнинг	5935091	2017.07.27	440
16	XV-019260	Хэнтий	Жаргалтхаан	Хадагтайн хөндий	1 333,40	Бүхэлд нь	Профигеологи	5508762	Монголын метал майнинг групп	5481694	2017.07.24	420
17	XV-019512	Дорноговь	Сайхандулаан	Могойт	4 030,62	Бүхэлд нь	Цандмань Каротаж	5543266	Маргац Интернэшнл голд	5955963	2017.07.31	464
18	XV-019513	Хэнтий	Батноров	Баянхаан	2 332,88	Бүхэлд нь	Гео орон ресурсис	5611857	Жи энд Т ресурсес	6195423	2017.07.26	438
19	XV-020854	Увс	Тариалан	Даваат	5 945,12	Бүхэлд нь	Өнөө орших булаг	5754992	Руби стоун	6077455	2017.07.04	392
20	XV-003828	Булган	Дашинчилэн	Доргоногт, Улаан ухаа	1 360,28	Бүхэлд нь	Алтандорнод монгол	2112868	ПЛ майнинг	5926629	2017.07.27	456
		Төв	Заамар		220,95							
21	MV-006006	Дархан-Уул	Шарынгол	Буянтан хөндийн адаг	91,96	Бүхэлд нь	Эрдэсхолдинг	2655772	ЧЧБТ	5763177	2017.07.21	410
		Сэлэнгэ	Баянгол		13,41							
22	XV-016057	Баянхонгор	Баян-Өндөр	Улаан	370,63	Бүхэлд нь	Лидер	2673371	Лидер эксплоэйшн	6183077	2017.07.16	396
			Шинэжинст		1 409,57							
23	MV-016889	Баянхонгор	Баян-Овоо	Бууцаг уул	117,81	Бүхэлд нь	Ханшижир	2608758	Ногоон даваа	5893259	2017.07.16	394
			Галуут		544,98							
24	XV-019228	Төв	Бүрэн	Их	1 636,46	Бүхэлд нь	Моннаад	2794977	Арвижих орд	5950538	2017.07.31	465
			Дэлгэрхаан		1 693,19							
25	MV-020427	Булган	Дашинчилэн	Урд дэлэн	1,47	Бүхэлд нь	Заамарын их алт	2670801	Уулсаамаар	2819996	2017.07.31	463
		Төв	Заамар		35,11							
26	MV-020868	Төв	Заамар	Хайлааст	81,54	Тодорохой хэсгийг	Алтандорнод монгол	2112868	Заамар гоулд	5935539	2017.07.24	419

ХУЧИН ТӨГӨЛДӨР БАЙХ ХУГАЦААГ СУНГАСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Талбайн нэр	"Тухайн суманд хамаарах талбайн хэмжээ"	Эзэмшигч	"Эзэмшигчийн регистрийн дугаар"	Сунгасан огноо	"Шийдвэрийн огноо"	"Шийдвэрийн дугаар"
1	XV-013901	Хэнтий	Дархан	Баргилтын овоо	1 283,75	Цахирцагаан гол	5068053	2020.07.18	2017.07.24	426
2	XV-013908	Сүхбаатар	Онгон	Хар тойром	18 055,98	Кожеговь	2078449	2020.07.22	2017.07.18	401
3	XV-013912	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Хөх нүдэн	13 875,55	Кожеговь	2078449	2020.07.22	2017.07.27	451
4	XV-013929	Өмнөговь	Цогт-Овоо	Дутгих уул	887,20	Рийч-Оре	5427347	2020.07.28	2017.07.18	403
5	XV-013938	Дундговь	Өлзийт	Шивээгийн гозгор	1 864,73	Си Эм Си Эм	5370108	2020.07.28	2017.07.24	427
6	XV-013964	Увс	Хяргас	Дэлгэрэх	4 861,99	Цэрэнбадам	5166667	2020.08.04	2017.07.27	448
7	XV-013984	Дундговь	Баянжаргалан	Артаг гуншинг	565,05	Атлангастар	5168619	2020.08.08	2017.07.27	448
8	XV-013986	Дундговь	Гурвансайхан	Элгэний худаг	1 396,12	Эм Эн Эл Жи	5154715	2020.08.08	2017.07.24	426
9	XV-014008	Улаанбаатар	Багахангай	Бор тал	82,49	Мэжикстэйшин	5141893	2020.08.13	2017.07.31	468
10	XV-014024	Хөвсгөл	Арбулаг	Зүүн хүрэн чулуут	809,45	Эм Жи Ти Жи	5257557	2020.08.18	2017.07.27	445
11	XV-014027	Хөвсгөл	Арбулаг	Нуурын	2 379,01	Эм Жи Ти Жи	5257557	2020.08.18	2017.07.31	468
12	XV-014043	Өмнөговь	Ханхонгор	Хэрэм худаг	7 072,03	Данхаргоулд	5250978	2020.08.20	2017.07.27	446
13	XV-014049	Өмнөговь	Хүрмэн	Хүрээ-2	28 654,86	Голденгоби майнинг	5340624	2020.08.25	2017.07.27	445
14	XV-014091	Төв	Борнуур	Харганы ам-1	1 031,71	Туншан шандон	5161975	2020.07.31	2017.07.24	427
15	XV-015079	Дорноговь	Эрдэнэ	Дэрт хотгор	10 873,68	ЖАСКО	5194997	2021.08.21	2017.07.27	446
16	XV-017024	Дундговь	Өлзийт	Шивээгийн гозгор	240,95	Си Жи Си Эм	5581729	2020.07.28	2017.07.18	403
17	XV-013936	Дархан-Уул	Шарынгол	Бэрх уул	21,17	Хосбогд	5157145	2020.07.28	2017.07.24	427
		Сэлэнгэ	Баянгол		1 572,99					
18	XV-014017	Сүхбаатар	Дарьганга	Дунд нарт	47 847,60	Кожеговь	2078449	2020.08.18	2017.07.27	453
			Наран		4 829,80					
19	XV-014031	Дорноговь	Өргөн	Хартан овоо	12 417,11	Эгшиглэнт-Уул	5107776	2020.08.20	2017.07.27	446
		Сүхбаатар	Баяндэлгэр		483,51					
20	XV-014032	Өмнөговь	Баяндалай	Толгод	3 486,87	ЭРБЖЭР	5195381	2020.08.20	2017.07.27	445
			Гурвантэс		942,35					
			Ноён		69 261,53					

ТАЛБАЙГ БУЦАН ӨГСӨН

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Буцаасан талбайн хэмжээ (га)	Буцаасан хэлбэр	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар
1	XB-014252	Булган	Бүрэгхангай	Захцагийн ам	267,15	Бүхэлд нь	Хүслэмж	2872722	2017.07.31	470
2	XB-014258	Булган	Бүрэгхангай	Туулын зүүн дэнж	343,18	Бүхэлд нь	Хүслэмж	2872722	2017.07.31	470
3	XB-017031	Хэнтий	Өмнөдэлгэр	Өмнөдэлгэр	131,36	Бүхэлд нь	Нутгийн мана	5196175	2017.06.13	310
4	XV-013871	Сүхбаатар	Эрдэнэцагаан	Боролт ухаа	7 479,96	Тодорхой хэсгийг	Кожеговь	2078449	2017.07.18	402
5	XV-014070	Дундговь	Гурвансайхан	Гургадлай	8 703,84	Тодорхой хэсгийг	Жи Эн Ти Эл	5157641	2017.07.21	412
6	XV-012600	Өмнөговь	Ноён	Хар сэвэгэн	4 593,17	Тодорхой хэсгийг	Энхтунх орчлон	5618339	2017.07.31	469
7	XV-013907	Сүхбаатар	Асгаг	Шүүт	1 862,36	Тодорхой хэсгийг	Кожеговь	2078449	2017.07.27	452
			Дарьганга		15 456,17					
8	XV-014017	Сүхбаатар	Дарьганга	Дунд нарт	7 602,88	Тодорхой хэсгийг	Кожеговь	2078449	2017.06.29	377
			Наран		2 459,35					
			Онгон		4 644,34					

БАРЬЦААНД БҮРТҮҮЛСЭН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Барьцаалагч	Барьцаалагчийн регистр	Шийдвэрийн огноо	Шийдвэр #
1	MV-001781	Булган	Тэшиг	Цагаан шар	153,41	Централ эшиа майнинг	5005094	Улаанбаатар хотын банк	2637545	2017.07.27	449

ОБЪЕКТАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо энэ жил 55 жилийн ойтойгоо золгож буй. Тус холбооныхон ойн баяраа өнгөрсөн сард тэмдэглэн өнгөрүүлсэн юм. Ингээд тус холбооны гүйцэтгэх захирал Б.Цэвэлмаатай цөөн хором ярилцсанаа хүргэе.

-Эмэгтэйчүүдийн эрх ашгийн төлөө дуу хоолойгоо хүргэхэд анхаарч ажилладаг нь мэдээж хэрэг юм. Та холбооныхоо эрхэм зорилгыг тодорхойлооч?

Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Дархан-Уул аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо нь "Эрдэм боловсрол, Эрч хүч, Эв нэгдэл-Хамтын хүч" гэсэн уриатай. Эмэгтэйчүүдийнхээ үзэл

Энэ мэтээр үргэлжилсээр бид энэ оны аравдугаар сард аянаа өндөрлүүлэхээр төлөвлөдөг байна. Дараагийн нэг ажил бол өөрсдийн нөөц, боломж бололцоондоо тулгуурлаж, мөн бидэнд хандив өргөн хамтран ажилласан хувь хүн, албан байгууллагуудынхаа тусламжтайгаар Эмэгтэйчүүдийн ордныхоо гадна, дотор засварын ажлыг хийлээ. Мөн ордныхоо урд талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар нэлээд их тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэлээ. Бидний энэ их ажлыг дэмжиж, хамтран ажиллаж хандив, туслалцаа үзүүлсэн байгууллага, хувь хүмүүстээ маш их баярлагатай байгаа энэ даш-

Б.ЦЭВЭЛМАА:

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО БОЛ БИДНИЙ НЭГДЭЛ

бодол, нийгмийн байдал, сүсэг бишрэл, яс үндэс, хөрөнгө чинээ, албан тушаал зэргийг үл харгалзан тэдний нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлэн хамгаалах, төрөөс эмэгтэйчүүдийн талаар баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох болон эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэхэд оршиж байгаа нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

-Аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлд хэцүүн хүн багтаж байгаа вэ?

Дархан-Уул аймгийн эмэгтэйчүүдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүд нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй. Холбооны дэргэдэх Хяналтын зөвлөл гурван хүний бүрэлдэхүүнтэй. Салбар салбарын манлайлагч эмэгтэйчүүд ажилладаг.

-Аймгийн эмэгтэйчүүдийн холбооны 55 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд ямар ажлуудыг хийв?

Аймгийн эмэгтэйчүүдийн холбоо үүсгэн байгуулагдсаны түүхт 55 жилийн ой, Эмэгтэйчүүдийн ордон байгуулагдсаны 30 жилийн ойг бид өнгөрсөн сард тэмдэглэн өнгөрүүлсэн. Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд, хамгийн түрүүнд Дархан-Уул аймагтаа "Хайр дүүрэн гар" аяныг өрнүүлж, аяныхаа нээлтийн үйл ажиллагааг ёслол төгөлдөр эхлүүлсэн. Аяны хүрээнд эмэгтэйчүүдээ эхний тусламжуудаа хүргээд байна. Уг аянд маань хөдөлбөр халамжийн байгууллагаас байнга тусламж аваад байдаггүй, өрх толгойлсон, ажил хийе гэсэн ч ажилд авдаггүй, өвчтэй боловч боломжгүйн улмаас хэвтэн эмчлүүлж чаддаггүй, амьдралд нь жаахан дэм болоод өгвөл урагшлах боломжтой эмэгтэйчүүдийг хамруулж байгаа. Бид аянаа эхлүүлэхийн өмнө буюу гуравдугаар сарын 02-оос эхлэн тусламж үзүүлэх эмэгтэйчүүдийнхээ судалгааг багийн Засаг дарга болон эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нартайгаар хамтран эхлүүлсэн. Улмаар тавдугаар сарын 20-д аяны нээлтээ хийсэн. Дархан-Уул аймгийн томоохон албан байгууллагууд, хувь хүмүүс маань аянд нэгдэж байгаа учир бид дараалалтай бас сонирхолтойгоор аяныхаа үйл ажиллагааг амжилттай явуулах зорилгоор шилжин явах цомыг эхний байгууллага болох "Дархан Ус суваг" ХК-д гардуулсан. Тус компанийн хамт олон гурван эмэгтэйд тусалсан.

рамд хэлмээр байна. Дараагийн нэг том ажил маань Монголын эмэгтэйчүүдийн холбооноос жил бүр уламжлал болон зохион байгуулдаг "Зуны сургалт" тойрон аялыг аймагтаа зохион байгуулж байна. Зуны сургалтад Монгол Улсын 21 аймгийн эмэгтэйчүүдийн төлөөлөл хүрэлцэн ирж, манай аймгийн түүх дурсгалт газруудтай танилцахаас гадна харилцан туршлага хуваалцаж байгаад байртай байна.

-Зуны сургалтыг аймагтаа зохион байгуулж байна. Өмнөх жилүүдийн сургалтуудаас юугаараа онцлог болж байна вэ?

Аймаг аймгийн газарзүй болоод ёс заншил өөр өөрийн гэсэн илэрхийлэлтэй байдаг. Манай хот бол Монгол Улсын хоёр дахь том хот. Энэ том хотын эмэгтэйчүүдийн байгууллага 55 жилийн түүхэн ойтойгоо золгож байна. Нөгөөтгэйгээр МЭХ-ны уламжлалт "Зуны сургалт" тойрон аялын 20 жилийн ойг иргэд олон нийтэд сурталчлах, Хөгжлийн загвар Дархан хотын эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааг нийслэл, дүүрэг, 21 аймгийнхаа эмэгтэйчүүдтэй хуваалцах зорилгоор энэ жилийн зуны сургалтыг өөрийн аймагтаа зохион байгуулах хүсэлтийг тавьсан. Энэ дагуу манай аймагт Улаанбаатар хот, нийслэлийн есөн дүүрэг, 15 аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийнхөн хүрэлцэн ирэхээр мэдүүлгээ өгөөд байна.

-Холбооны гишүүн байгууллагууд эмэгтэйчүүд, эхчүүдийн эрх ашгийг хамгаалсан ямар ажлуудыг хийж байна. Ер нь Дарханы эмэгтэйчүүдийн байгууллага сүүлийн жилүүдэд ямар амжилттай ажиллаж ирэв?

55 жилийн түүхтэй Эмэгтэйчүүдийн холбоо маань Монголын эмэгтэйчүүдийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд жил бүр хийсэн ажлын тайлангаа хүргүүлж, хийсэн ажил

маань дээгүүр байр эзэлдэг нь бидний хувьд амжилт юм. Одоо төсөл хөтөлбөрөөр санхүүжин хэрэгжиж байгаа Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв, Үсчний сургалтын төвийн ажлууд амжилттай явагдаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн томоохон байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд гээд 20 орчим гишүүн байгууллагатай. Өөр өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалж, эмэгтэйчүүдийн эрх ашиг, жендерийн эрх тэгш байдал хангагддаггүй. Бид энэ тал дээр хамтран ажиллаж сургалт зөвлөгөө өгөх замаар хамтран ажилладаг.

-Эмэгтэйчүүдийн холбооны нэрэмжит олон ажлуудыг нэрлэж байна. Хамгийн сайхан ажил нь ямар ажил вэ?

Миний хувьд бол эмэгтэйчүүдийнхээ төлөө хийж байгаа бүх л ажил минь сайхан. Энэ дундаас онцолбол Цэнгэлсайхан даргын үеэс жил бүр уламжлал болон эдүгээ 22 дахь жилдээ зохион байгуулагдсан "1000 ээжийн баяр"-ын үйл ажиллагаа маань хамгийн сайхан нь. Олон сайхан эзгүүд эмэгтэйчүүд, буурлуудаа баярлуулж чаддаг сайхан ажил юм.

-Аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага гэж та дээр хэллээ. Байгууллагын санхүүгийн асуудлыг хэрхэн шийддэг вэ. Таны дээр хэлсэн ажлуудыг хэрэгжүүлэхийн тулд нэлээд их хөрөнгө мөнгө шаардагдаж байгаа байх?

Мэдээж тэгэлгүй яах вэ. Энд манай байгууллага гишүүд дэмжигчид, анхан шатны болон удирдах зөвлөлийн гишүүд, хамран ажиллагч байгууллагууд болон нутгийн удирдлагын байгууллагынхаа тусламжтайгаар үйл ажиллагаа зохион явуулдаг юм. Дэм дэмэндээ, дээс эрчиндээ гэдэг дээ. Бид хамтдаа эв нэгдэлтэй байж эдгээр ажлуудаа хэрэгжүүлж чаддаг юм.

зөвлөл дарга, тэргүүлэгчид гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг учир холбооноос зохион явуулж буй үйл ажиллагаануудад манай зөвлөлийн дарга нар маань маш идэвхтэй эмэгтэйчүүдээ татан оролцуулдаг.

-Гадаад улс орнуудын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч ажиллах төлөвлөгөө бий юу?

Байлгүй яах вэ. Гадаад улс орнуудын эмэгтэйчүүдийн байгууллагуудынхаа талаар судалгаа хийж, харилцаа тогтоож, хамтран ажиллах бидний бас нэгэн том зорилт юм.

-Эмэгтэйчүүдийн идэвх оролцоо ямар байна?

Манай аймгийн эмэгтэйчүүд сэтгэлээрээ маш сайхан дэмжин хүлээн авч идэвхтэй оролцдог. Бид цаашид аймгийнхаа бүх л эмэгтэйчүүдийг татан оролцуулах зорилготой олон төрлийн ажлыг зохион байгуулна.

-Холбооны дэргэдэх сургалтуудад эмэгтэйчүүд маань хэрхэн хамрагдаж байна вэ?

Холбооны дэргэдэх гар урлал, дээл хувцас оёх, даалин урлах, шүрэн эдлэл хийх зэрэг сургалтуудыг охид, эмэгтэйчүүд маань маш их сонирхон суралцаж байгаа. Энэ жилээс бид Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв, Үсчний сургалтын төвийг мэргэжлийн өндөр төвшинд явуулахаар ажиллаж байна. Мөн Хууль, эрх зүй, сэтгэл зүй, жендерийн эрх тэгш байдлын талаар шаг даралсан сургалт семинар явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

-Танай аймаг шиг өөрийн гэсэн эмэгтэйчүүдийн ордонтой холбоо бусад аймагт байдаггүй байх аа?

Манай аймгийн эмэгтэйчүүдийн ордон барьж байгуулагдсанаас хойш эдүгээ 30 жилийн ойтойгоо золгож байна. Энэ бидний хамгийн том бахархал юм. Зарим аймгууд маань өөрсдийн байр, ордонтой болж байгаа.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Олон улсын Жоужицүгийн ТЭМЦЭЭНЭЭС НАЙМАН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Монголын жоужицүгийн холбоо Арабын нэгдсэн Эмират улсын жоужицүгийн холбоотой хамтран "Ulaanbaatar international pro" олон улсын тэмцээнийг энэ сарын 5-нд зохион байгууллаа. Тэмцээнд АНУ, БНХАУ, Их Британи, Казахстан, ОХУ,

Араб, Тажикистан, Узбекистан, Монгол гэсэн есөн орны 140 гаруй шилдэг тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн байна. Улмаар тэмцээнээс Сэлэнгэ аймгийн тамирчид гурван алт, гурван мөнгө, хоёр хүрэл медаль хүртжээ.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

Олон улсын стандартад нийцсэн спорт цогцолбортой боллоо

Дархан-Уул аймагт 21 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр баригдахаар төлөвлөгдсөн "Спорт цогцолбор"-ын барилгын ажил 2011 онд эхэлсэн ч 2014 онд хөрөнгө оруулалт нь зогсож царцаагдсан барилгын тоонд ороод байсан. Харин 1.5 тэрбум төгрөгийг энэ жилийн төсөвт суулгаснаар төсөл үргэлжлэх боломжтой болсон юм. Одоогоор барилгын ажлын явц 55 хувьтай байна. 2019 он гэхэд уг барилгыг ашиглалтад оруулахын тулд үлдсэн найман тэрбум төгрөгийг ирэх онд яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа тухай барилгын гүйцэтгэгчээр ажиллаж байгаа "Нэмбар" ХХК-ийн захирал О.Нэмэхболд УИХ-ын гишүүн Б.Жавхлан болон БСПУС-ын яамны холбогдох албаны хүмүүсийг аймаг орон нутагт ажиллах үеэр танилцуулжээ.

Шинээр баригдаж байгаа "Спорт цогцолбор" нь нийт 20.000 м2 талбайтай бөгөөд 2200 хүний суудалтай спорт заал, 240 хүний суудалтай олон улсын стандартад нийцсэн таван зам бүхий 25 метр урттай усан бассейн, тамирчдын бэлтгэлийн өрөө, хувцас солих өрөөтэй байхаас гадна бүх төрлийн спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, бэлтгэл хийх танхимуудтай байх аж. Мөн тамирчдад зориулсан 120 хүний ортой зочид буудал, зоогийн газар, хурлын танхим ч багтах юм байна. Ийм хэмжээний хүчин чадалтай цогцолбортой болсноор улсын болон олон улсын чанартай спортын бүх төрлийн уралдаан тэмцээнийг аймаг орон нутагтаа зохион байгуулах бүрэн боломж нээгдэх юм.

Өнөөдрийн хувьд 100 гаруй мянган хүн амтай Дархан-Уул аймаг 1964 онд ашиглалтад орсон 600-800 хүний багтаамжтай спортын ганц ордонтой. Аймгийн хэмжээнд спортын 22 төрлийн дугуйлан секц хичээллэдэг ч заалны багтаамж, тоног төхөөрөмжийн хангамж зэрэг тулгамдсан олон асуудлаас шалтгаалан сагс, гар бөмбөг, софт теннис, үндэсний бөх гэсэн дөрвөн төрлийн дугуйлан л спортын ордны зааланд хичээллэдэг байжээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

Баг, тамирчдад 2.5 сая гаруй төгрөгний дэмжлэг үзүүллээ

Дорноговь аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа" /2016-2020/ үйл ажиллагааны хөтөлбөрт дасгал, хөдөлгөөнөөр хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, дэлхий, тив, олон улсын тэмцээнд өндөр амжилт гаргах шилдэг тамирчдыг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, биеийн тамир, спортоор хичээллэх, ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар тусгасан. Тэгвэл тус ажлын хүрээнд Эрдэнэт хотноо болох "Үндэсний цом-2017" насанд хүргэгчдийн холбөмбөгийн тэмцээнд оролцох Ч.Багзагна дасгалжуулагчтай "Түмэн од" хөл бөмбөгийн клубын тамирчид болон нийслэлд зохион байгуулагдах Олон улсын хүүхдийн спортын VII дугаар наадамд оролцох аймгийн бокс, чөлөөт бөхийн холбооны баг, тамирчдад нийт 2.5 сая гаруй төгрөгний дэмжлэг үзүүлжээ.

ХЭНТИЙ АЙМАГ

Сумдын Засаг дарга нар туршлага хуваалцлаа

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын ЗДТГ-аас санаачлан Баян-Овоо, Баянмөнх, Мөрөн сумдын хамтарсан уулзалт арга хэмжээг хоёр өдрийн турш сумандаа зохион байгууллаа.

"Төрийн албаны чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын манлайллыг дээшлүүлэх, чадварлаг, үр дүнд чиглэсэн төрийн албыг бүрдүүлэх, харилцан туршлага судалж ажиллахад энэхүү арга хэмжээний зорилго оршиж байгаа юм" хэмээн Баян-Овоо сумын Засаг даргын орлогч Д.Ганбаатар ярьсан юм.

Арга хэмжээний эхний өдөр төр түмнийхээ төлөө ажиллаж буй гурван сумын ЗДТГ-ын ажилтнууд өөр хоорондоо ажлын туршлага, санал солилцож, сумдын удирдлагууд нь өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлуудаасаа танилцуулж, шинэлэг санаа, ажлын арга барилаасаа хуваалцлаа. Мөн элсний волейболын тэмцээн, гурван сумын ЗДТГ-ын ажилтнуудын хамтарсан "Бидний дуу" урлагийн тоглолт зохион байгуулж, ард иргэдэд хүргэв. Харин хоёр дахь өдөр нь Баян-Овоо сумын есөн гайхамшигтай танилцаж, Есөн хүний агуйд хээрийн цай ууцааж, Гүрмийн нуурын хөвөөнөө чөлөөт амралт зохион байгуулснаар арга хэмжээ өндөрлөсөн байна.



-Холбооныхоо үйл ажиллагаанд орон нутагт байгаа эмэгтэйчүүдээ хэрхэн татан оролцуулж байна вэ. Гишүүнчлэл ямар төвшинд байна?

Дархан-Уул аймаг дөрвөн сумтай. Дархан сумын 18 багт манай холбооны эмэгтэйчүүдийн зөвлөл ажилладаг. Хонгор, Орхон, Шарын гол сумдад сумын эмэгтэйчүүдийн зөвлөл ажилладаг. Нийт 21 эмэгтэйчүүдийн

-Залуу хүний хувьд эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэхээр зориг шулууджээ. Өмнөө тавьсан ойрын зорилго тань юу вэ?

Баярлалаа. Хийж бүтээхээр төлөвлөсөн ажлуудаа энэ ондоо багтаан үйл ажиллагаагаа жигдрүүлж, аймгийнхаа эмэгтэйчүүдийг улам идэвхжүүлэн хамтран ажиллах л миний ойрын зорилго юм даа.

ЗАВСАРЛАГА

ТОМИЛОЛТ

ӨНДӨР ГЭГЭЭНИЙ НУТГИЙНХАН

ӨРГӨН ДЭЛЭР НААДАВ



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Н.БАТЗАЯА

Хүүхэд, багачуудын гийнгоо цангинаж, хүчит бөхийн барилдаанд хорхойссондоо өөрөө босоод барилдах нь уу гэлтэй сандал дээрээ өндөлзөн суух ахмадууд, өнгө алагласан монгол дээлээ жавхайтал бүслэсэн охид бүсгүйчүүд, амаа мэдэхгүй үрээндээ ташуур нэмэн хурдлах хүдэр эрчүүдээс шүү сайхан нь орчлон ертөнцөд үгүй мэт санагдана. Ай даа эх орны минь баруун элгэнд эрхлэх Өврийн сайхан хангай нутгийн наадам хурд, хүч, дуу хуур, айраг, цагаан идээнд бялхан өргөн дэлгэр боллоо. Энэ жил Өвөрхангай аймгийн Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны түүхт 290 жилийн ойн баяр наадам, ойн хамт “Арвагар хээрийн их хурд-2017” хангайн бүсийн уралдаан, “Монгол түмний морины их шүтээн цогцолбор”-ын 10 жилийн ой тохиож, наадамчин олны сэтгэлийг баягалаа. Тус нутгаас Монголын анхны гэсэн эрдэмтэн мэргэд, генерал, гавьяатунд төрөн гарсан түүхтэй. Тухайлбал, Өндөр гэзгэн Занабазар, БНМАУ-ын баатар Л.Аюуш, олон түмнээ “Мээтэн” гэж алдаршсан Монгол Улсын арслан О.Аюур, Төрийн соёрхолт, яруу найрагч Ц.Гайтаа, Монгол Улсын Гавьяат жүжигчин Д.Галсанбат гэх зэргээр дурьдаад байвал дуусашгүй. Эх орныхоо төлөө хөдөлмөрлөж, ихийг бүтээж чадсан энэ л алдартнуудын өлгий нутаг, түүхт Арвайхээр хотынхоо 290 жилийн ойн баяр наадамд зориулж, нутгийн удирдлагууд хэд хэдэн томоохон бүтээн байгуулалтын ажил хийжээ. Дээрх ажлаа наадмын өдрүүдэд танилцуулж байлаа. Тодруулбал, Монгол Улсын дархан аварга Д.Цэрэнтогтохын гэрэлт хөшөөг босгож, сум дотроо хатуу хучилттай зам шинээр тавьсан гээд олон бүтээлч ажлаар ойн баяраа угтсан нь ард иргэдийн талархлыг хүлээ.

Хүчит бөхийн барилдаанд Т.Санчир түрүүлээ



Түүхт Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны баяр наадмын хүчит бөхийн барилдаанд нийт 128 бөх зодоглосноос Өвөрхангай аймгийн Хархорин сумын харьяат, “АПУ” хувьцаат компани, Хилийн цэргийн 0146 дугаар анги, Их Монголын Хүчтэн Дэвжээний бөх улсын өсөх идэр заан Т.Санчир түрүүлж, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын харьяат, “Алдар” спорт хороо, Зэвсэгт хүчний 150 дугаар анги, “Алтан Дорнод Монгол” компани, “Бөх Билэгт” дэвжээний бөх улсын арслан Р.Пүрэвдагва үзүүрлэж наадамчин олноо баярлуулсан юм. Харин Өвөрхангай аймгийн Уянга сумын харьяат, “Алдар” спорт хороо, Зэвсэгт хүчний 0101 дүгээр анги, “Контейнер Хаус” компани, Их Монголын Хүчтэн Дэвжээний бөх улсын харцага Х.Гантулга, Өвөрхангай аймгийн Тарагт сумын харьяат, Өвөрхангай аймгийн цагдаагийн газар, “МАКС” групп, Их Монголын Хүчтэн Дэвжээний бөх улсын начин Б.Сангисүрэн нар их шөвөгт шалгарав.



Арвайхээр хотод 0.788 км хатуу хучилттай зам тавьжээ



Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 290 жилийн ойн баяр наадмын хүрээнд бүтээн байгуулалтын олон ажил тус суманд өрнөж байна. Түүний нэг нь 0.788 км үргэлжлэх замын ажил юм. Тэгвэл энэ сарын 28-нд дээрх хатуу хучилттай замын нээлт боллоо. Нээлтийн үйл ажиллагаанд тус аймгийн Засаг дарга Г.Ганболд тэргүүтэй холбогдох албаны хүмүүс оролцов. Уг үйл ажиллагааг нээж, Өвөрхангай аймгийн Засаг дарга Г.Ганболд “Арвайхээрчүүд бид түүхт 290 жилийн ойн баяраа угтан олон бүтээн байгуулалтын ажил хийж байгаагийн нэг нь I-IX дүгээр багийн чиглэл дэх 0.788 км бүхий явган болон авто замыг барин өнөөдөр хүлээлгэн өглөө. Зам дагаж хөгжил ирнэ гэж монголчууд ярьдаг. I-IX дүгээр багийн иргэд ая тухтай, тоос шороогүй тохилог орчинд амьдрах нөхцөл бүрдлээ. Нөгөө талаас зам дагаж дэлгүүр, худалдаа үйлчилгээний байгууллагууд ажиллах боломжтой болсон. Цаашид аймгийн ИТХ, Засаг даргын зүгээс Арвайхээр сумын автозамын сүлжээг өргөтгөж бодлогыг нэн тэргүүнд баримтлан ажиллана. Мөн УИХ-ын гишүүдтэй хамтран Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гудамж” төслийг аймагтаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр дэд бүтцийн хувьд томоохон хот болох боломж нээгдэнэ. Энэхүү 0.788 км хатуу хучилттай замын бүтээл байгуулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн компанийн хамт олонд талархал илэрхийлэе” гэв. Уг замын ажлыг “Өндөрсант хайрхан” компани гүйцэтгэсэн бөгөөд нийт 618 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн байна. Нээлтийн үеэр тус компанийн хамт олон гэрээнд заасан хугацаанаас өмнө замын ажлаа хүлээлгэн өгсөн хэмээн онцолж байв.

“Халхын хар аварга”-ын гэрэлт хөшөө сүндэрлэв

Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны 290 жилийн ойн хүрээнд хийж, хэрэгжүүлсэн олон ажлын нэг нь олноо “Халхын хар аварга” хэмээн алдаршсан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, даяар дуурсагдах дархан аварга Д.Цэрэнтогтох агсны хүрэл хөшөө байлаа. Уг хөшөөний нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 28-нд болсон бөгөөд Өвөрхангай аймгийн спортын төв ордныг мөн Д.Цэрэнтогтох аваргын нэрэмжит болгосон юм. Томдсон малгай, гутал өмссөн дөрвөн жаалаар хүрээлүүлж зогссон хүрэл өнгөтэй хөшөө бол улсад дөрөв түрүүлж, таван удаа үзүүрлэж, 21 удаа шөвгөрсөн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин, дархан аварга Д.Цэрэнтогтох



агсных. Хүү төрвөл дандаа бөх болоорой гэж бэлгэшээдэг монголчуудын бэлгэдлийг бодож, аймгийнхаа нэрийг дуурсгасан бөх олноор төрөөсэй гэж ерөөн, өвөрхангайчууд Д.Цэрэнтогтох агсны хөшөөг ийн дөрвөн бөх хүүгээр хүрээлүүлжээ. Дөрвөн хүүгийн хөшөөг нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум буюу аваргын төрсөн нутгаас боржин чулууг авчирч сийлсэн аж. Хөшөө нь 5.7 метр өндөр, дороо суурьтай. Мөн Д.Цэрэнтогтох аваргын ид залуудаа барилдаж, улсад анх түрүүлж байсан үеийн дүр төрхөөр бүтээснээрээ онцлог юм. Д.Цэрэнтогтох агсны дурсгалын хөшөөний нээлтэд Өвөрхангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд болон гэр бүл, багш, найз нөхөд, шавь нар оролцож, сэтгэлийн үгээ хэлсэн юм. Тухайлбал, Д.Цэрэнтогтох агсны гэргий О.Отгон “Ханийн минь хөдөлмөрийг үнэлж, хөшөөг нь босгосон нутгийн удирдлагууддаа маш их баярлалаа. Нутгийнхаа нийт зон олон, Өвөрхангай аймгийн Засаг дарга Г.Ганболд, Өвөрхангай аймгийн Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн дарга С.Чинзориг болон бусад бүх хүмүүст маш их баярлаж байна. Миний ханийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж, хөшөөг босгож байгаад туйлын их баяртай байна. Өвөрхангайчууддаа ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Мөн энэ жил манай сумын 290 жилийн ой тохиож байгаа. Төвийн бүсийн наадамдаа шандаст хүлгүүд нь хурдан, хүчит бөхчүүд нь хүчтэй, сум нь мэргэн байж, сайхан наадаарай” хэмээн талархал илэрхийлсэн юм.

100 өрхөд гэр олгов

Арвайхээр хот үүсэн байгуулагдсаны 290, “Арвагар хээрийн их хурд-2017” хангайн бүсийн уралдаан, “Монгол түмний морины их шүтээн цогцолбор”-ын 10 жилийн ойн баяр наадмын үеэр баяр дээр баяр нэмсэн нэгэн үйл явдал болсон юм. Тодруулбал, орон нутгаас сонгогдсон эрхэм гишүүд, аймгийн удирдлагуудад гэр хүссэн өргөдөл, хүсэлт их ирдэг бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор УИХ-ын гишүүдийн санаачилга, дэмжлэгтэйгээр 2017 онд орон нутгийн төсөвт 100 гэр олгох санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэжээ. Арвайхээр хот байгуулагдсаны 290 жилийн ойн хүрээнд уг гэрт ойд урилгаар ирсэн зочид, төлөөлөгчдийг нэгдсэн зохион байгуулалтаар байрлуулан, ойн дараа сумдын иргэдэд хуваарилан хүлээлгэн өглөө. Гэр хүлээлгэн өгөх ажиллагаанд УИХ-ын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн, Я.Содбаатар, аймгийн Засаг дарга Г.Ганболд, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дарга С.Ундрах нар болон сум, багийн Засаг дарга нар оролцож, иргэдэд гэрийг нь гардууллаа. Дээрх гэр нийлүүлэх тендерт ялсан “Хүлгийн хурд” ХХК нь орон нутагтаа 200 сая төгрөгийн санхүүжилт бүхий гэрээний дагуу иж бүрэн гэрүүдийг бэлтгэсэн бөгөөд гэрийн модыг Бат-Өлзий сумаас бэлтгэн нийлүүлсэн байна.